

МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРЭН БА “ИХ ЮАНЬ”

Ким Ходон¹

Солонгос хэлнээс орчуулсан Г. Эрдэнэчимэг²

- I. “Их Юань” ба “Их Монгол улс”
- II. “Их Юань” ба “Юанийн хаант улс”
- III. “Хаан улс”
- IV. Эзэнт гүрний нэгдмэл шинж
- V. Дүгнэлт

Хубилай хаан өргөмжлөгдсөн 1260 оныг түүнээс хойшхи үеийн Монголын эзэнт гүрний түүхэнд гарсан шийдвэрлэх өөрчлөлтийн эх болсон хэмээн үзэж иржээ. Тухайлбал, түүний урд жил буюу 1259 оны хаврын 7-р сард Мөнх хаан Өмнөд Сүн улсыг эзлэн авахаар дайлаар мордож, баруун жигүүрийн цэргийг толгойлж явах замдаа Сычуань нутгийн Дяоюйшань-д гэнэт өөд болоход зүүн жигүүрийн толгойлогч Хубилай цэргээ эргүүлэн умардыг зорьж, 1260 оны 3-р сар (5.5) одоогийн Өвөр Монголын өндөрлөг талд орших өөрийн түшиц газар Зиньяньчуань-д (金蓮川, хожмын Кайпины Шаньду) ирээд хаан болжээ³. Ингээд дараа сар нь Монголын уудам талд Хархорумын баруунтайх Алтангол гэдэг газар өөрийгөө хаан өргөмжилсөн дүү Аригбөхтэй дайтаж эхлэсэн ба 5-р сар (6.29)-д хятад маягаар оны цолоо “жүндү (中統)” гэж зарлалаа. Аригбөхийг бууж өгсөн даруй 1264 онд оны чимгээ “жи-юань (至元)” гэж өөрчлөв. Хубилай 1267 онд Алтан улсын нийслэл байсан Жүндү-тэй ойрхон газар шинэ нийслэл байгуулахыг зарлигджээ. 1271 оны 11-р сар (12.18)-д тэрбээр Алтан улсын Тайхэ хуулийг (泰和律) цаашид бүү дага хэмээн тушаагаад улсын цолыг “Их Юань” хэмээн зарлан тунхаглаж, дараа жил нь 1272 оны 2-р сард шинээр байгуулсан нийслэлээ “Дайдү” хэмээн нэрийдлээ⁴.

Эдгээр арга хэмжээг Хубилай их хааны суудлын төлөө тэмцэх явцдаа эзэнт гүрний нийслэлийг Шаньду улмаар Дайдүд шилжүүлж, Өвөр Монгол ба Хойт Хятадыг түшиглэн “хятад маяг”-

¹ Сөүлийн Их Сургуулийн Хүмүүнлэгийн Ухааны Сургуулийн Дорно дахины судлалын тэнхмийн профессор

² МУИС, ГХСС-ийн Солонгос судлалын тэнхмийн багш

³ Хубилайн цэргээ буцаасан тухай Сүгияма Масааки-гийн (杉山正明) 「クビライ政権と東方三王家」 『東洋學報』 54(1982), pp. 257-315 (『モンゴル帝国と大元ウルス』, 京都大學學術出版會, 2004 pp.62-126-д дахин тэмдэглэсэн)-ийг үзнэ үү.

⁴ 『元史』, 卷4(世組1), pp.63-66; 卷7(世組4), pp.138-140. Хуудасны тоог 中華書局 標點本-наас авав.

ийн хаант улс байгуулах гэсэн хүсэл эрмэлзлийн илрэл гэж эрдэмтэд үзэж иржээ. Жишээлбэл, хятад маягаар оны болон улсын цолыг тунхагласан анхны монгол хаан юм. Гэхдээ иймэрхүү билэг тэмдгийн арга хэмжээнээс гадна хаан суусан даруйдаа төвлөн захирах байгууллага болох Төвлөн удирдах яам байгуулж, Ван Вэньтуныг (王文統) Цэрэг, улсын хүнд хэргийг тэгшлэн шийтгэгч сайдаар (平章政事), Жан Вэньцян-г (張文謙) зүүн гарын сайдаар (左丞) томилсон ба орон нутгийн засаг захиргааны хэргийг хариуцдаг Арван замын цэргийн түшмэдээр (十路宣撫使)⁵ хятад хүнийг томилох зэргээр олон хятад хүнийг төрийн албанд авсан байна⁶. Мөн Аригбөхтэй хийсэн тэмцэлд хэдийгээр ялсан авч тэрхүү хагарал тэмцлийн дунд Зүчийн удмын Бэрх, Цагаадайн удмын Алгү, Тулуйн удмын Хүлэгү зэрэг баруун талын хүчирхэг хаад улс төрийн хувьд тусгаарлан бие даасан тул Монголын эзэнт гүрэн үнэндээ “задарсан” явдал байлаа. Тийм учраас Хубилайн засаглал тогтсон, хятад маягийн тогтолцоог хүлээн авч хэрэгжүүлсэн, баруун зүгт гурван хант улс бие даасан энэ гурван үйл явдал бараг л нэг цаг хугацаанд өрнөснөөр “Юаний хаант улс тогтносон” хэмээн ойлгогдож ирсэн байна⁷.

Ингэж үзэх аваас сүүлийн үед Монголын эзэнт гүрэн задарсан гэдэг үзлийг шүүмжлээд, Хубилайн эзэнт гүрнийг “том бага улсууд нэгдсэн, нэгэн төрлийн “дэлхийн холбооны улс” гэж үзсэн Масааки Сүгияма-гийн санал анхаарал татна⁸. Зохиогч би бээр түүний энэ үзэл бодлыг сайшаан дэмжиж байгаа ч “Их Юань” гэдэг ухагдахууны талаар илүү сайн дэлгэрүүлэн хэлэлцэх хэрэгтэй гэж үзэж байна. Энэхүү өгүүлэлдээ “Монголын эзэнт гүрэн” ба “Их Юань” хэмээх хоёр нэр ухагдахууны хувьд харилцан ямар холбоотой болохыг шинжлэн үзээд Хубилайн засаглалаас хойшхи Монголын эзэнт гүрний түүхэн бодит байдлыг илүү тодорхой ухаж ойлгоход тус болох хэлэлцүүлгийн эхлэлийг тавихыг зорив.

I . “Их Юань” ба “Их Монгол улс”

1271 оны 12-р сарын 18-нд Хубилай улсаа “Их Юань” гэж нэрлэхээр тогтсоноо мэдэгдэхээр “Улсын цол, оны цол тунхаглах бичиг, 建國號詔” -ийг зарлан тунхагласан бөгөөд тэр нь бүрэн эхээрээ “Юань улсын судар”, “Юань улсын хууль цаазын бичиг (元典章)”-т бий⁹. Энэ жуу бичигт Хятадын эртний хаант улсууд улсаа нэрлэхдээ дагаж мөрдөж ирсэн зарчим, тухайлбал Цинь, Хань-тай адил хүчирхэгжин гарсан газар нутгийн нэрээр юм уу эсвэл Суй, Тан улстай адил соёрхолд авсан “мэдэх газар(爵邑)”-ын нэрээр нэрлэж ирсэн уламжлалыг тохиромжтой бус гэж үзээд Чингэс хаан бээр үндэслэн байгуулснаас хойш монголчуудын хийж бүтээсэн “их үйлс”-д таарч тохирох нэрээр нэрлэх хэрэгтэйг дурдаж, 『Зурхайт ном』 -д гардаг “大哉乾元” гэдэг үгийн утгаар “Их Юань, (大元)” хэмээн нэрлэхээр тогтсон тухай тодорхой тэмдэглэжээ. “『經世大典 (Ертөнцийг засах магад хууль)』 -ийн 『書錄·帝號 (Тэмдэглэл · Хаадын нэр)』 -нд Юань гэдэг

⁵ Тан улсын үед бий болсон цол бөгөөд 1260 онд Хубилай хаан ор суухдаа Яньжисин, Бэйжисин зэрэг газарт Арван замын цэргийн хороог байгуулж, цэргийн түшмэд суулгажээ. Цэргийн түшмэд нь засаг захиргаа хариуцдаг байснаа хожим нь салж, зөвхөн цэргийн хэрэг хариуцах болжээ. (орч.)

⁶ 『元史』, 卷4(世組1), pp.63-66.

⁷ Монголын эзэнт гүрэн 1260 онд 4 хант улс болон задарсан гэдэг үзэл, түүний улмаас Хятадын нэгэн хаант улс болох Юань улс байгуулагдсан гэдэг үзэл эдүгээ хэт түгээмэл байгаа бөгөөд ийм үзлээр бичсэн ном зохиолыг бүгдийг дурдах боломжгүй хэдий ч, Өрнө Дорнын гол бүтээлээс нэрлэвэл, D. Morgan, *The Mongols* (Cambridge, UK, 1986); 韓儒林 主編 『元朝史』 (北京, 1986); 愛宕松男・寺田隆信, 『中國の歴史』, 卷6: 元・明 (東京, 1974).

⁸ 杉山正明・北川誠一, 『世界の歴史』, 卷9: 大モンゴル時代 (東京, 1997), pp.139-140.

⁹ 『元史』, 卷7(世組4), pp.138-139; 『大元聖政國朝典章』 (臺北, 國立故宮博物院印行, 1976), 卷1(詔令1).

үгийг дараах маягаар тайлбарлажээ. Юань гэдэг нь их гэсэн үг. Томорсоор түүнээс их, түүнээс том зүйл үгүй болсныг зааж буй тул Юань гэдэг нь том, ихийн туйл (人之至) юм.”¹⁰ Эндээс бид “Их Юань (大元) гэдэг улсын нэр нь “том” гэсэн утгыг туйлаас онцолсон хийсвэр ухагдахуун бөгөөд урьдын Хань, Тан улсууд өөрийн улсыг өргөмжлөн дээдлэх үүднээс Их Хань, Их Тан улс гэж нэрлэж байснаас огт өөр шинж чанартай, өөрөөр хэлбэл анхнаасаа л нанхиад хоёр үсгээс тогтсон улсын нэр (二字國號) болохыг мэдэж болно. Гэтэл ингэж угаас хоёр үсгээс тогтсон “Их Юань” хэмээх нэрийг Их Хань, Их Тан зэрэг улсын нэртэй жишиж, 大 хэмээх нанхиад үсгийг өөрийн улсыг өргөмжлөсөн тэмдэг нэрийн утгаар ойлгосны улмаас “Юань” гэдэг нэрээр, нанхиад ганц үсгээс бүтсэн нэр мэтээр хэрэглэх болсон бөгөөд үүнийг ‘皇元 · 我元’ зэрэг жишээ харуулна.

Гэтэл бас монголчууд өөрсдийн байгуулсан төрт улсыг монгол хэлээр “Их Монгол улс” гэж нэрлэснийг олноор мэднэ. Чухам хэдийгээс албан ёсоор ингэж нэрлэхээр зарлан тунхагласан тухай сурвалж мэдээ олдохгүй боловч, анх удаа албан ёсоор тэмдэглэсэн нь бидэнд мэдэгдэж байгаар 1246 оны 11-р сард бичиж Карпини ламд даатган 4-р Инносент хамба ламд дамжуулсан Гүюг хааны бичигт дарсан тамганы бичигт гардаг. Уйгар үсгээр сийлсэн энэ тамгын бичигт :

Möngke tngri-iyen küchün-dür Yeke Mongghol Ulus-un dalay-in khan-u jrlq хэмээх мөр буй. Гэхдээ энд буй Yeke Mongghol гэдэг үгийг улсын нэр гэж шууд хэлэхэд хэцүү. Учир нь улс гэдэг үг нь юуны өмнө “олон хүн, ард түмэн” гэдэг утгыг агуулдаг тул “Их Монгол улс” гэдэг үгийг улсын нэр буюу хэвшиж тогтсон оноосон нэр бус зүгээр л “их Монгол улс түмэн” гэдэг утгаар ойлгож болох юм. Гүюг хааны илгээсэн захидлын оршилд түүнтэй тохирох мөрөнд түрэг хэлээр “küŕ ulugh ulus” гэж байгаа бөгөөд монгол гэдэг үг огт байхгүй¹¹, мөн түүнээс барагцаагаар 20 жилийн өмнө Чингис хааныг амьд сэрүүн байхад үйлдсэн болов уу гэж үздэг “Чингисийн чулууны бичиг”-т монгол хэлээр “qamugh Mongghol ulus” хэмээн тэмдэглэсэн¹² зэргээс үзэхэд ингэж таамаглах нь илүү үнэмшилтэй.

Өнгөрсөн цагийн Евразийн тал нутгийн нүүдэлчидтэй адил монголчууд бас Хятад юм уу бусад суурьшмал улстай адилгүй улсын болон оны цол тогтоон зарлан тунхаглаж заншиж дадаагүй гэж үздэг. Монголын эзэн хаад өөрийн биеийг нийт монголчуудын захирагч гэдэг утгаар “Хамаг Монгол улс”, эсвэл “Их Монгол улс”-ын хаан хэмээн нэрлэж, энэ нь хожим хойно аажмаар хэвшиж тогтсоор нэгэн төрлийн улсын нэр мэтээр хэрэглэх болсон байх тун боломжтой. Юань улсын үед хийсэн үй олон нанхиад бичигтэй чулууны бичээст “Их Юань” гэдэг улсын нэр юм уу эсвэл түүний үүсэн байгуулагдсан оныг илэрхийлэх оны цол заавал тэмдэглээстэй байдаг атал уйгар юм уу дөрвөлжин бичиг төдийгүй 白話聖旨碑 буюу хааны зарлигийн монгол эхийг хятад хэлний ярианы найруулгаар орчуулж сийлсэн хөшөөний бичиг зэргийг нягтлаваас тэдгээрийн эх юм уу адаг хэсэгт ‘長生天’ (möngke tdngri-ийн хятад орчуулга) гэдэг үг юм уу эсвэл өмнөх эзэд хаадын тухай дурдсан хэсэг, мөн арван хоёр жилээр он жилийг тэмдэглэсэн байхаас бус улсын нэр, оны цол огт гардаггүй нь монголчуудын энэ мэт өвөрмөц уламжлалаас үүдэлтэй гэж хэлж болох юм¹³.

¹⁰ 『國朝文類』(四部叢刊初編集部, 上海: 商務印書館 印行), 卷40, p.413

¹¹ Энэ талаар шүү дэлгэрэнгүй үзье гэвэл P. Pelliot, *Les Mongols et la Papauté* (Paris, 1923), pp.15-25.-ыг харна уу.

¹² L. Ligeti, *Monuments préclassiques*, vol. I (X IIIe et X IVe siècles) (Budapest, 1972), p.17.

¹³ Уйгар бичгээр бичсэн сурвалжийн талаар өмнө ишлэсэн L. Ligeti-ийн *Monuments préclassiques*, vol. I-ыг, дөрвөлжин бичгийн талаар L. Ligeti-ийн *Monuments en écriture P ags-pa Budapest*, 1972) ба N. Poppe, *The*

Ингээд үзвэл “Их Монгол улс” гэдэг үг анхнаасаа улсын нэр болж тогтвортой хэрэглэгдэж байгаагүй ч байж болох юм. Гэхдээ цаг хугацаа өнгөрөхийн хэрээр улсын нэр мэтээр хэрэглэж эхэлсэн бизээ. Өмнө дурдсан “Ертөнцийг засах магад хууль”-ийн 「書錄·帝號 (Тэмдэглэл·Хаадын нэр)」-нд “Хубилай хаан анх удаа Их Монгол гэдэг нэрийг Их Юань гэж өөрчиллөө. (世祖皇帝初易大蒙古之號而 爲大元也)” гэсэн нь түүний нэг жишээ болно¹⁴. Сяо Цицин (肅啓慶) зоос болон хөшөөний бичээс, түүхэн сурвалж зэргийг нягтлан судласны дүнд “Их Юань” гэдэг улсын нэрийг тунхаглахаас өмнө ‘大朝 (Юаний хаант улс)’, ‘大蒙古國 (Их Монгол улс)’ гэдэг хоёр янзын нанхиад нэрийг хэрэглэсэн бөгөөд ялангуяа эхнийхийг нэн түлхүү хэрэглэж байснаа уг хоёр нэр нь хоёулаа “Их Юань” гэдэг нэрээр солигдон хэрэглэхээ больсон¹⁵ гэжээ. Ингэж үзэх аваас “Ертөнцийг засах магад хууль”-нд гарч буй ‘大蒙古’, ‘大蒙古國’ гэдэг хоёр үг үсгийн хувьд яг таарахгүй байгаа ч “Их Монгол улс” гэдэг үгийг нанхиадаар орчуулсан нэг үг гэдэгт эргэлзэх хэрэггүй болно. Тиймээс Хубилай хаанаас өмнө “Их Монгол улс” болон түүний нанхиад орчуулга болох ‘大蒙古(國)’ хоёр хамтдаа хэвшиж тогтсон оноосон нэр буюу улсын нэр байжээ гэдгийг мэдэж болохоор байна.

Тэгвэл “Ертөнцийг засах магад хууль”-нд гарч буй Хубилай хаан, “улсынхаа нэрийг анх удаа өөрчиллөө” гэсэн хэсгийг хэрхэн ойлговол зохих вэ. Тэрбээр “Их Монгол” гэдэг нэрийг хэрэглэхээ больж, түүнийг “Их Юань” гэдэг нэрээр сольсон, мөн Хубилайн авч явуулсан энэ арга хэмжээний улмаас “大蒙古”-гийн уугуул монгол үг болох “Их Монгол улс” хэмээх нэрийг хэрэглэхээ больсон гэж үзэх үү. Энэ тухайд огт тийм биш гэж хариулахаас өөр аргагүй. Нэг жишээ авъя. Төвлөн удирдах яамны Ляо Яны төлөөний яамны (遼陽行省), Цэрэг улсын хүнд хэргийг тэгшлэн шийтгэгч сайдын үүргийг давхар гүйцэтгэгч Жан Ин руйд (張應瑞) хааны соёрхсон <Жан овогт багшийн гэрэлт хөшөө, 張氏先塋碑>¹⁶ -ний бичиг нанхиад, монгол хоёр хэлээр байх бөгөөд монгол бичээс нь нанхиад бичээсийн орчуулга юм. Энд нанхиад эхэд гарч буй “皇元”-ийг монголоор “Yeke Mongghol Ulus” гэж орчуулсан ба 1346 онд босгосон “Зарлигаар соёрхсон Шинь Юаний гэрэлт хөшөө, (勅賜興元閣碑)”-ний бичигт ч мөн “我元” гэдэг үгийг “Yeke Mongghol Ulus” гэж орчуулжээ¹⁷. Түүнээс гадна 1338 онд үйлдсэн “Жун Сунь Дай Фу Даргач Жү Жунь-ий хөшөө, (中順大夫達魯花赤竹君碑)”-ний бичээсийн нанхиад эхэд гарах “大元” гэдэг үгийг монгол эхэд “Dai Цн кемекь Yeke Mongghol Ulus” гэж буулгасан байх¹⁸ ба 1362 онд босгосон “Их Юаний зарлигаар соёрхсон Ши Нин ван Шинь Дугуны гэрэлт хөшөө (大元勅賜追封西寧王忻都公神道碑)”-ний бичээсэнд “Dai Цн Yeke Mongghol Ulus” гэж гардаг.¹⁹ Эдгээр

Mongolian Monuments in H P'ags-pa Script (tr. J. R. Krueger; Weisbaden, 1957)-г, 白話碑-ны тухайд 蔡美彪-гийн 『元代白話碑輯錄』 (北京, 1955) болон бусад нанхиад бичээст хөшөөний талаар 『遼金元石刻文獻全編』 全三冊 (北京, 2003) зэргийг үзнэ үү.

¹⁴ Зүүлт (7)-г үзнэ үү.

¹⁵ 「說〈太祖〉: 元祖建號前蒙古的漢文國號」 『蒙元史新研』 (臺北, 1994), pp. 23-47.

¹⁶ 전계 『遼金元石刻文獻全編』 第1冊, 『滿洲金石志』 〈張氏先塋碑〉, pp. 813-817; F. Cleaves, “Tse Sino-Mongolian Inscription of 1335 in Memory of Chang Ying-jui,” *Harvard Journal of Asiatic Studies*, vol. 13, no. 1-2 (1950), pp. 1-131; Ligeti, *Monuments präclassiques* (vol. 1), pp. 36-50.

¹⁷ F. W. Cleaves, “Tse Sino-Mongolian Inscription of 1362 in Memory of Prince Hindu,” *Harvard Journal of Asiatic Studies*, vol. 12, no. 1-2 (1949), pp. 30, 62, 83.

¹⁸ 『遼金元石刻文獻全編』 第3冊, 『滿洲金石志』 〈中順大夫達魯花赤竹君碑〉 pp. 817-820; F. W. Cleaves, “Tse Sino-Mongolian Inscription of 1338 in Memory of Jiguntei,” *Harvard Journal of Asiatic Studies*, vol. 4, no. 1-2 (1951), pp. 27, 53, 67.

¹⁹ F. W. Cleaves, “Tse Sino-Mongolian Inscription of 1362 in Memory of Prince Hindu,” *Harvard Journal of Asiatic Studies*, vol. 12, no. 1-2 (1949), pp. 30, 62, 83.

хөшөөний бичээсүүд нь бүгд монгол маягийн нэр болох “Yeke Mongghol Ulus” хэмээх нэрийг Хятад дахь Монголын ноёрхол дуусах хүртэл хэрэглэснийг гэрчилнэ.

Эдгээр хөшөөний бичгээс бид тун чухал хоёр зүйлийг мэдэж болмоор байна. “大元”(Dai Цн) ба “Yeke Mongghol Ulus” гэдэг хоёр үгийг нэг утгаар хэрэглэж байжээ. “Dai Цн kemekъ Yeke Mongghol Ulus” гэдэг хэсэгт гарч буй kemekъ нь хэмээх гэсэн утгатай тул үүнийг шууд орчуулбал “Их Юань хэмээх Их Монгол улс” болно. “忻都公神道碑” хөшөөний бичигт “Dai Цн Yeke Mongghol Ulus” гэж гарч байгааг дээрх хоёр нэрийг зэрэгцүүлэн хэрэглэсэн гэж үзэхээс өөр аргагүй. Тэгвэл “Dai Цн Yeke Mongghol Ulus” нь нийтдээ эзэнт гүрний “албан ёсны нэр” бөгөөд нанхиад сурвалжид амрыг бодон эхний “大元”(Dai Цн)-ыг л салган авч нэрлэсэн гэдэг үзлийг зөвшөөрөх аргагүй.²⁰ Уг хоёр нэр, өөрөөр хэлбэл нанхиад маягийн нэр ба монгол маягийн нэр нь хоёулаа Монголын эзэнт гүрэн гэдэг нэг л объектыг заан нэрлэсэн болох нь дээрх хөшөөний бичгийн хэл найруулгаас тодорхой харагдаж байгаагийн зэрэгцээ уг хоёр нэр утгын хувьд ч нэг л утгатай. Өмнө дурдсанчлан эзэнт гүрэн төвхнөсөн эхний үед хэрэглэсэн олон нанхиад нэрний нэг ‘大蒙古(國)’-ийг “Yeke Mongghol Ulus”-ын шууд орчуулга гэж үзэж болох бөгөөд ‘大朝’ ч язгуурын монгол нэрэн дундах “Yeke” гэдэг ухагдахууныг онцолсон нэр. “大元” гэдэг мөн л “Зурхайт ном”-ын “大哉乾元” гэдэг үгнээс авсан нэр агаад “元” гэдэг үсгийн утга нь “туйлын том” гэсэн утгатай тул “大元” нь “Yeke” гэдэг ухагдахууныг туйлаас онцгойлон төвийлгөсний учир юм²¹.

Бид ‘大元 = Их Монгол улс’ гэдэг тэнцэтгэлийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй бол ‘大元’ нь Монголын эзэнт гүрэн задарсны дараа түүний нэг хэсэг улс, тухайлбал Хубилайн байгуулсан Хятад төвт улс бус, харин Оросоос Номхон Дөлгөөн далай хүртэлх бараг л Евразийг тэр чигт нь эзэлсэн Монголын эзэнт гүрнийг заан нэрлэсэн нэр бөгөөд ‘大元’ гэдэг нэр бол “Их Монгол улс”-ын нанхиад орчуулга төдий гэдэг дүгнэлтэнд хүрч байна. Жишин өгүүлвээс ‘The United States Of America’ гэдэг нэрийг бид ‘美國’ гэж хятад маягаар дууддагтай адил гэж хэлж болно. Тиймээс ‘美國’, мөн ‘米國’ гэдэг нэрийг Солонгос, Хятад, Япон гурван улсаас өөр оронд хэрэглэдэггүйтэй адил ‘大元’ гэдэг нэр ч мөн Зүүн Азийн ханз үсгийн соёлтой орнуудаас өөр оронд хэрэглэж байсангүй. Хубилай улсаа ‘大元’ гэж нэрлэхээр тогтсон тухайгаа Корйө, Аннам хоёр улсад л зарлан мэдэгдсэн нь түүнийг гэрчилнэ.²² Мэдээж Япон мөн ханз үсэг хэрэглэж байсан ч 1266 оноос эхлэн хэд хэдэн удаа илгээх гэж оролдсон Хубилай хааны захидал хүрээгүй бөгөөд 1270-аад оноос Японыг дайлахаар бэлдэж эхлэсэн²³ тул ‘Улсын цол, оны цол тунхаглах бичиг, 建國號詔’-ийг Японд илгээх аргагүй байлаа. 1274, 1281 онд хоёр удаа Монголын түрэмгийлэлд өртсөн япончууд, монголчуудыг “зэрлэг монголчууд (蒙古凶徒)” хэмээн нэрлэж, ‘大元’ гэдэг албан ёсны нэрнээс илүүтэйгээр “蒙古” гэдэг нэрийг түгээмэл хэрэглэж ирсэн гэж үзэж байна.²⁴

²⁰ 近藤成一編, 『モンゴルの襲来』(日本の近代史9, 東京2003), 120-122-р талд буй Сүгияма Масааки-гийн тайлбарыг үзнэ үү.

²¹ 前掲 蕭啓の「説く大朝: 元祖建號前蒙古的漢文國號」, pp.44-45; 陳高華, 『元の大都』(佐竹靖彦譯, 東京: 中央公論社, 1984), p.49.

²² 『元史』卷167「張立道傳」, p.3216, “[至元]八年, 復使安南, 宣建國號詔”; 『高麗史』卷27, 元宗12年十二月己亥“家古遣使, 告建國號曰大元”.

²³ Японд илгээсэн жуу бичгийн талаар池内宏, 『元寇新研究』(東京, 1931), pp.29-47, pp.89-116; 旗田巍, 『元寇』(東京, 1965), pp. 52-100 зэргийг үзнэ үү.

²⁴ 池内宏, 『元寇新研究』, p.314. “Умардын он жилүүдийн тэмдэглэл 『北條年代記』” гэдэг өгүүллэгт 至元29(1982)年七月條に“附商船歸朝, 大元燕公南獻牒狀” гэж гардаг. Хятадын Шар мөрнөөс өмнөх нутагт худалдаа хийхээр очсон Японы худалдааны усан онгоц буцахдаа Жянь Жэ мужийн бүх хэргийн түшмэл(江浙行省參知政事) Янь Гун нань(燕公楠)-ий захидал(牒狀)-ыг авчирсан онцгой үйл

Ингэж үзэх аваас ‘大元’ гэдэг нэрийг ханз үсгийн соёлтой орнууд дундаас Монголын эзэнт гүрний олон улсад тогтоосон улс төрийн дэг журмыг хүлээн зөвшөөрсөн орнуудад л хэрэглэж байсан гэж дүгнэхээс өөр аргагүй.

II. Их Юань ‘大元’, Юаний хаант улс ‘大朝’

Их Юань (大元) гэдэг нэр Монголын эзэнт гүрнийг нийтэд нь нэрлэсэн нанхиад маягийн нэр гэдэг дээрх дүгнэлтийг зөвшөөрөх аваас Их Юань улс (大元) бол Монголын эзэнт гүрний нэг хэсэг, өөрөөр хэлбэл, Эл хант улс, Цагаадайн улс, Кипчакийн хант улс гэсэн дөрвөн үе залгамжилсан улсын нэг болох Юаний хаант улс (大朝)-ын нэр хэмээн одоог хүртэл бидний үзэж ирсэн ойлголт буруу болж байна уу. Тийм, үгүй гэж шууд хариул гэх аваас тийм гэж хэлэхээс өөр аргагүй. Гэтэл энэхүү “буруу үзэл ойлголт” нь удаан хугацаанд хэвшиж тогтсон төдийгүй дийлэнх судлаачдын баримталдаг үзэл байх аваас бид ядахнаа л уг “буруу үзэл ойлголт” яаж бий болж, хэрхэн хэвшиж тогтсон талаар бодож үзэх шаардлагатай болов уу. “Хятад” гэдэг ухагдахууны хүрээ, мөн энэ ухагдахуун хэрхэн үүсч хэвшин тогтсон түүхийн талаар хоёр янзын эсрэг тэсрэг үзэл бодол зэрэгцэн оршиж байгаа нь асуудал үүсгэдэг.

Өнөөдөр бид “Хятад”-ыг улс төр, түүх, газар нутгийн тодорхой хүрээнд төр улс гэж ойлгодог. Гэхдээ энд анхаарах ёстой нэг чухал зүйл бол Монголын эзэнт гүрний ноёрхолд Хятад орсон тэр цаг үед бүх хүмүүс ингэж ойлгож байгаагүй гэдэг явдал юм. Мэдээжээр хань үндэстэн (тэр тусмаа орчин цагийн хятад иргэд), Хятад хэдийгээр удаан хугацаанд хагарал тэмцэл, үймээн самуунтай байсан ч Хань, Тан улсаас хойш төрт улсын уламжлалаа тасралтгүй хадгалж ирсэн бөгөөд Юань гүрэн түүхийн тавцнаа гарч ирснээс хойш өмнөд умардын удаан хугацааны хагарал тэмцэл эцэс болж, тэнгэрийн дорхийг нэгтгэж чадсанаар Хятад хэмээх нэгэн ертөнц дахин сэргэсэн гэж үздэг. Бид тухайн цаг үеийн хятад бичгийн хүмүүсийн Монголын эзэн хаадад өргөсөн бичгүүдэд Их Юань бол Хань, Тан, Сүн улсыг залгамжилсан Хятадын уламжлалт хаант улс болохыг онцлохын зэрэгцээ Хятадын хэв ёс, тогтолцоог хэрэгжүүлж, улсаа буянт засаглалаар засахын төлөө хичээн чармайхыг ухуулан ятгасаныг олонтаа олж үзэж болно. Жишээлбэл, “Оны цол, улсын нэрийг тогтсоны учир урьдын хөгжин мандсан үетэй зэрэгцүүлүүштэй, тэнгэрийн дорхийг нэгтгэн шинэтгэсэн тул Хань, Тан улсын амжилт гэж хэлүүштэй”²⁵ гэсэн юм уу, “Эдүгээ дөрвөн далай нэгэн бүл болж, түмэн иргэн хуран чуулав. Төрийн ёсыг чандлан сахих ёстойн учир олон сайд түшмэд өглөө бүр хаанд бараалхах ёсыг гүйцэлдүүлэх хэрэгтэй”²⁶ гэжээ. “Хаан ширээнд суусан жилээс нь эхлэн Ляо, Алтан улсын төрийн түүхийг бичиж хэвлэхийг”²⁷ Хубилайд сайд түшмэдүүд санал болгосон нь мөн л Их Юань бол Хятадын уламжлалт хаант улсын нэг мөн гэдэг итгэл үнэмшлээс үүссэн хэрэг юм.

Гэхдээ энэхүү “Нэг Хятад” гэдэг ухагдахууныг хань үндэстэн бус, бусад хүмүүс бүгдээр хүлээн авсан бус гэдгийг ойлгох хэрэгтэй. Жишээлбэл, Эл хаант улсын хааны ордонд монгол хааны зарлигаар Монголын эзэнт гүрний түүхийг бичсэн Рашид Ад-дин “Судрын чуулган”-даа “Хятад” гэдэг улсын талаар дурдсан зүйл огт үгүй бөгөөд түүнтэй тэнцэх ямар нэг нэр

явдлыг тэмдэглэсэн тул (уг номын 431-ээс 432-р тал) ‘大元’ гэдэг улсын нэр тухайн үед Японд өргөн танигдсан байсан гэж үзэх арга огт үгүй. Монголын довтолгооноос хойш Зүүн Азийн олон улсын дэг журмын тухай 南基, 『家古襲來鎌倉幕府』 (東京, 1996), 177-оос 233-р талыг үзнэ үү.

²⁵ 郝經, 『陵川集』 卷32 「立政議」.

²⁶ 元史, 卷160 「徐世隆得」, p.3770.

²⁷ 『元史』 卷4 「世祖. 一」, p.71.

томьёо хэрэглэсэн удаа ч үгүй. “Дэлхийн хамгийн анхны түүх” гэдэг нэрэндээ дүйхээр уг номонд дэлхийн улс үндэстэн бүрийн түүхийг бичсэн ба түүнд эрдэмтдийн “Хятадын түүх” гэж нэрлэдэг хэсэг бий²⁸. Гэхдээ энэ бол хожмын эрдэмтдийн өгсөн нэр төдий, уг эхэд байгаа нэр нь “Китайн хаадын түүх” (Tárokn-i aqvám-i pádisháhán-i Khitáo), эсвэл “Китай ба Манжийн хаадын түүх” (Tárokn-i pádisháhán-i Khitáo va Máchon) юм. Тухайн үед монголчууд ба персүүдийн хувьд “Хятад” гэдэг ухагдахуун байгаагүй, зөвхөн Китай (Khitai), Манж (Manzi) гэдэг хоёр өөр газар орон л байжээ²⁹.

Марко Пологийн “Дорно зүгт аяласан тэмдэглэл”-д ч мөн ямар нэг орон нутгийн нэгж гэж ойлгоогүй бөгөөд түүнтэй дүйх нэр ч олдохгүй. Мөн адилаар “Судрын чуулган”-д өнөөгийн Хятад нь Катаи (Catai), Манж (Manzi) гэсэн хоёр том хаант улс болон бусад жижиг орон нутгуудаас бүрджээ³⁰. Түүний зохиол олонд тарснаас хойш “Их хаан Хубилай”-н хаант улс европчуудын тархинд гүн хоногшив. Зүйл бүрийн эд бараа, эрдэнэсээр бялхсан, хязгааргүй уудам газар нутагтай хаант улс, Ханбалиг (Cambalus, 大都), Шаньду (Xanadu, 上都) Чуаньжоу (Zaitun, 泉州) зэрэг хотууд итали худалдаачдын хүслэн болсон газар болжээ. Марко Пологийн зохиолыг уншаад гүн сэтгэгдэл төрсөн худалдаачид, шашин номлогчид “Их Хааны улс” Катаи-г зорин замд гарав. Харин 1368 онд Мин улс төвхнөж, Хятадыг хэдийн нэгтгэчихсэн байсан тул, мөн Катаи бол даруй Хятад гэдгийг мэдээгүй учраас Катаи хэмээх хаант улсыг олж чадаагүй нь зүйн хэрэг. XVI зууны сүүлээр европчуудаас үүнийг анх удаа ухаарсан хүн бол Матео Ричи (Matthew Ricci) бөгөөд өөрийн нээлтийг тухайн цаг үеийнхэндээ ойлгуулах гэж ихэд зүдэрсэн гэдэг³¹.

Нөгөө талаар XIV зуунд Хятадаар зорчсон Ибн Батута, аяллын тэмдэглэлдээ Хятадыг бүхэлд нь Шин (Şin) гэж нэрлэжээ. Энэ нь мэдээж Chin (秦) гэдэг дуудлагыг араб маягаар тэмдэглэсэн нь бөгөөд Монголын байлдан дагууллаас өмнө Хятадтай хуурай замаар бус, усан замаар харилцаж ирсэн арабчуудад Хятад нь Шин гэдэг нэрээр танигдсан байлаа³². Ибн Батута Хятадыг Шин гэж зоригтой нэрлэсэн нь ийм уламжлалтай. Гэхдээ Монголын ноёрхлын үед Хятадад очоод Умард Хятадыг тусад нь “Кита (Khitv)” гэж нэрлэсэн нь сонирхол татна³³. Тэрбээр Ханжоу (Khanza, 杭州)-аас хойшхи нутгийг “Кита” нутаг гэсэн ба энэ нь умард Хятадыг “Китаи”, “Катаи” гэх зэргээр нэрлэсэн дээрх жишээнүүдтэй дүйж байна. Ийм нэрийг мэдээгүй араб гаралт Ибн Батута Хятадад очоод умард Хятадыг “Кита” гэж нэрлэсэн нь тухайн үеийн хятад бус гадны иргэдийн дунд өргөн тархсан ойлголтыг тусгасан сонирхолтой баримт юм.

²⁸ K. Jahn, *Die Chinageschichte des Rašjd ad-Džn* (Wien, 1971); 本田實信, 「ラシド・ウッ・デインの『中國史』」 『モンゴル時代史研究』 (東京:東京大學出版會, 1991), pp.387-404.

²⁹ Жишээлбэл, “Чингэс хааны намтар” (Ким Ходон-ы орчуулга, Сэгежэл, 2003), 273-274-р тал. Kitay гэдэг үг нь хятан 契丹 (Kitan) гэдэг үгнээс гаралтай. Manzi ба Nangiyas нь тус тус ‘子’ ба ‘南家子’ гэдэг ханзыг дуудлагаар нь тэмдэглэсэн үг бөгөөд өмнөд Сүн улсыг дорд үзэн нэрлэсэн нэр юм. Jaugui-ын талаар P. Pelliot ‘趙官’ (趙 нь өмнөд Сүнийн хааны овог)-ны монгол хэлний олон тооны хэлбэр гэж үзжээ. *Notes on Marco Polo* (Paris, 1950), pp.227-229-г үзнэ үү.

³⁰ Марко Пологийн “Дорно зүгийн улс оронд аяласан тэмдэглэл” Ким Ходон-ы орчуулга, Сэгежэл, 2000, 295-р талаас хойш иш татав.

³¹ *China in Sixteenth Century: The Journals of Matthew Ricci: 1583-1610* (tr. L. J. Gallagher Jr., New York: Random House, 1953), pp.311-15, Pelliot, *Notes on Marco Polo* (3 vols., Paris: Librairie Adrien-Maisonneuve, 1959-79), vol. 1, pp. 216-29

³² Хэлли Юл, Анри Кордэй, “Хятад руу явах зам”, (Жон Сү-ил-ийн орчуулга, Сэгежэл, 2002), 49-р тал.

³³ H.A.R. Gibb & C.F. Beckingham tr., *The Travels of Ibn Baṭṭūṭa, A.D. 1325-1354* (London, 1994), p.905; “Ибн Батутагийн аялалын тэмдэглэл” (Жон Сү-ил-ийн орчуулга, Бүтээл ба шүүмжийн түүх, 2001), 2-р боть, 341-р тал.

Энэчлэн тухайн үеийн монгол, перс, араб, европчууд Хятадыг нэг улс, нэг нутаг орон гэж үзэхгүй, дор хаяж хоёр, тэгээд түүнээс олон тус тусдаа бие даасан хаант улс, орон нутаг хэмээн үзэж байсан нь оргүй хоосноос бий болсон санаа биш. Х зууны эхээр Тан задран унасны дараа Хятад нь удаан хугацаанд умард өмнөд хоёр хэсэгт хуваагдсан, өөрөөр хэлбэл Х III зуунд монголчууд Хятадыг ноёрхох хүртэл 300 гаруй жилийн туршид хуваагдмал байдалтай байлаа. Монголчуудын хувьд Хятадыг нэгдмэл нэг улс гэж ойлгох ямар ч үндэслэл байсангүй, “Китай”, “Манж” гэдэг нэр бол Төв Азийнхан юм уу монгол, зөрчидүүдийн хэрэглэж байсан нэр томьёог тэр чигээр нь дагасан хэрэг юм. Мөн Монголын ноёрхолд орсон Хятад оронд зорчсон харийхан (өнгөт нүдтэн) голцуу монгол, перс, түрэг хэлээр харилцдаг байсан тул хань үндэстэнтэй хятад хэлээр харилцах нь цөөн байжээ. Марко Поло 17 жил Хятадад суухдаа хятад хэл огт сураагүй, ханз үсгийн тухай дурдаа ч үгүй нь түүний тод жишээ мөн³⁴. Тиймээс гадаад орныхон “нэг Хятад”-ын тухай ямар ч ойлголтгүй байсан нь зүйн хэрэг.

Ялангуяа монголчуудад хятад маягийн, “хаант төрийн түүхийг үзэх үзэл (王朝史觀)” туйлаас харь хөндий зүйл байсан нь тодорхой. Хаант төрийн залгамж халаа шинжийг онцолдог түүхийг үзэх үзэл болоод тодорхой нутаг дэвсгэрт нэг хаант улс нөгөөгөөр солигдон, өмнөх хаант улсын түүхийг бичиж тэмдэглэн дараа дараагийн үед хадгалж хамгаалдаг явдал нь суурьшмал иргэдийн хувьд түгээмэл үзэгдэл боловч нүүдлийн амьдралтай, бичиж тэмдэглэх гүехэн уламжлалтай нүүдэлчдэд тэр мэт хаант улсын залгамж халааг онцлох үзэл ойлголт бараг байхгүй. Түүнээс эсрэгээр хаант улсуудыг тус тусад нь авч үздэг түүхийг үзэх үзэлтэй. Хүннү, Түрэг, Уйгар, Хятан, Монголын аль нь ч өмнөх хаант улсынхаа залгамж халаа гэдгээрээ бахархан гайхуулсан тухай баримт олдохгүй төдийгүй тэр талаар ямар ч үзэл ойлголт байхгүй мэт байна. Эдгээр улсууд нь тус тусдаа тэнгэр (tdngri 天)-ийн ивээлээр төвхнөн мандсанаараа бахархдаг, энэ нь монгол хаадын зарлиг бичигт “тэнгэрийн зарлиг (天命)” бус харин “мөнх тэнгэрийн хүчин (mǒngke tdngri-yin kúchūn)”-г онцлон үздэгээс харахад тодорхой байна. Монгол хаад, хань үндэстэн өөрсдийг нь “тэнгэрийн хүү” гэж үздэгийг мэдэхгүй байх учиргүй, мөн өөрт нь ноогдуулсан хуанди цолоос татгалзаагүй боловч тэглээ гээд өөрийн биеийг хятад хуанди болчихлоо гэж үзээгүй нь лавтай. Монголын эзэн хаад бол юуны өмнө олон үндэстэнг нэгтгэн захирсан “хаан” байсан бөгөөд “хуанди” бол “хаан”-ы нэг тал төдий л байжээ. Тэд Хань, Тан улсыг уламжлан залгасан Хятадын нэгэн хаант улсын хаан гэж өөрийн биеийг үзээгүй, тийм учраас хань үндэстний итгэсэн шиг “Их Юань=Хаант улс (Хятадын уламжлалт хаант улс. орч.) (大元=大朝)” гэдэг ухагдахууныг хүлээн зөвшөөрөх нь учир дутагдалтай юм.

Энэ талаар сүүлийн үед Японы судлаачид Юаний хаант улс (大朝)-ийн оронд “Их Юань улс” гэдэг нэрийг түлхүү хэрэглэх болсон нь анхаарал татна. Энэ нь Юаний үеийн түүхийн судлагаанд өмнөх үеийн “хаант төрийн түүхийг үзэх үзэл”-ийн нөлөөнөөс ангижрах гэсэн ухамсраас үүдэлтэй хэмээн үзэж байгаа бөгөөд миний бие энэ тухайд санал нийлж байна. Гэхдээ “Их Юань улс”-ыг Хубилай болон түүний залгамжлагчдын захирсан Зүүн Азийг бүхэлд нь хамарсан улс, тухайлбал өнөөг хүртэл бидний Юаний хаант улс (大朝) гэж нэрлэж ирсэн газар нутгийг нэрлэсэн нэр болгон хэрэглэх аваас тэр нь “Их Юань” хэмээх нэрний агуулдаг үндсэн утгыг гуйвуулсан хэрэг болно гэж үзэхээс өөр аргагүй.

³⁴ “Дорно зүгийн улс оронд аяласан тэмдэглэл”-д ханз үсгийн талаар огт дурдаагүй нь Марко Поло өөрийн биеэр Хятадаар аялаагүйн гэрч гэж үздэг талаар I. De Rachewiltz-ын няцаалтыг үзнэ үү. (“Marco Polo Went to China,” *Zentralasiatische Studien*, Wiesbaden, no. 27, 1997, pp. 55-57).

Х III-XIV зуунд Монголын ноёрхлын үеийн Хятадад энэ мэтээр хоорондоо адилгүй хоёр өөр, ертөнцийг үзэх үзэл зэрэгцэн оршиж байсан гэсэн үг. Их Юань бол хань үндэстний хувьд даруй Хятадын хаант улсын уламжлалыг залгамжилсан “Юаний хаант улс (元朝)” байсан бол монголчуудын хувьд Хятад нэгэн хэсгийг нь бүрдүүлдэг дэлхийн гүрэн “Их Монгол улс” байлаа. Гэлээ ч “Их Юань”-ийг Юаний хаант улс (元朝)-тай адилтган үзсэн тухайн үеийн хань үндэстний үзэл бодлыг үл хайхран (Их Юань=Их Монгол улс) гэдэг тэнцэтгэлийг зөвшөөрөх аваас мөн л юмны зөвхөн нэг талыг харсан гэдэг шүүмжлэлээс мултрахад хэцүү биз. Бид “Их Юань” гүрний энэ мэт хоёрдмол шинж, тухайлбал хань үндэстний нүдээр харсан “Хятадын хаант улс” гэдэг нэг тал, ноёлогч монголчууд тэргүүтэй хань үндэстнээс бусад хүмүүсийн нүдээр харсан “дэлхийн эзэнт гүрэн” хэмээх бас нэгэн талыг хоёуланг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй. Тэгээд энэхүү хоёр талыг түүхийн сурвалжид тулгуурлан тодруулах үед “Их Юань” улсын түүхэн бодит дүр төрхийг бид илүү тодорхой харах болно гэж бодож байна.

III. “Хаан улс”

Тэгэхээр өмнөх дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх аваас наад зах нь монголчуудын хувьд “Дди Цн” буюу Их Юань бол бидний санасанчлан Юаний хаант улс (元朝) биш болж байна. Тэгвэл одоог хүртэл бидний Юаний хаант улс (元朝) гэж нэрлэж ирсэн газар нутаг, тухайлбал Хубилай ба түүний залгамжлагчдын захирсан Зүүн Азийн тодорхой газар нутгийг эзэлсэн орныг монголчууд хэрхэн нэрлэж байсан бэ? Энэ бүс нутаг бол “Их Юань=Монголын эзэнт гүрэн”-ий дотроос баруун зүгт тогтсон гурван хант улсаас ялгаатай, их хааны шууд захирах нутаг гэж хэлж болох бөгөөд үүнийг тодруулсан тусдаа нэр байсан болов уу? Миний бие хэт эргэлзсэн байж болох, мөн түүхэн сурвалж дутагдалтайгаас шалтгаалсан ч байж болно. Юутай ч монгол хэлээр бичсэн хэрэглэгдэхүүн дундаас тийм нэр хараахан олдохгүй байна. Харин исламын ертөнцийн перс, араб хэлний хэрэглэгдэхүүнд дараах сонирхолтой баримт бий.

- Хаан ба Хайду ба Тогтаин (ülüs-I qv'vn va Qvīdū va Tōqtvī) улсаас дагуулж ирсэн монгол боолчуудын дунд ийм үндэстний харьяа боол хэд хэд байлаа³⁵.

- [Малиг Төмөр] арав хоногийн дараа хааны улс (mamlakat-I qvn)-ын хил хязгаарт ойрхон Ананд (Ananda)-ын бэлчээрт [хүрээд]...³⁶

- Яг энэ үед Хайшан хан(Khayshvng)-ы хаанчлах ээлж ирж, тэрбээр хаан улсын хааны (ülüs-I qvni) суудалд баттай суулаа³⁷.

- Дорнын олон хант улсын дотроос хамгийн том хоёр улс бий, [нэг нь] Хосроү-гийн хант улс буюу Иран[ы хант улс] бөгөөд Хүлэгүгийн угсааныхны эзэмшил болж, нөгөө нь Түраны хант улс бөгөөд хааны улс (mamlakat al-khvqvnīyat) өөрөөр хэлбэл Чингис хааны нутаг юм³⁸. (Онцлох хэсгийг доогуур нь зурж тэмдэглэв.)

Дээрх ишлэл өгүүлбэрт гарч буй qv'vn, qvn, khvqvn зэрэг нь бүгд хаан гэсэн утгатай үг ба хан (khvn)-гаас ямагт чандлан ялгаж тэмдэглэжээ. Мөн mamlakat бол араб, перс хэлний хаант улс гэсэн утгатай үг тул монгол хэлний улс гэдэг үгийн орчуулга мөн. Тиймээс дээрх өгүүлбэрүүдээс

³⁵ 라시드 앳 딘, 『칸의 후예들』, (김호동, 사계절, 2002), p.142; Muhammad Rawshan □□ (Tehran, 1994; Rashid/Rawshan), p. 73.

³⁶ Abū al-Qesim 'Abd Allāh b. Muhammad al-Qeshenī, *Tārīkh-i Īljā'itū* (Ed. By Muḥin Hambly, Tehran, 1348), p. 38.

³⁷ Ibid, p.148.

³⁸ V. Tizengauzen, *Sbornik mareialov, otnosiashchikhsia k istorii Zolotoi Ordyy, Tomi* (St. Peterburg, 1884), p. 332, p.340.

бид Өгөөдэйн угсааны Хайду ба Зүчийн угсааны Тогтай мөн Хүлэгүгийн угсааны хангууд бүгдээр "улс" эзэгнэж байсан ч тэднээс ялгагдах – хэдийгээр ямар хэлээр тэмдэглэснээс шалтгаалан бага зэрэг ялгаатай ч – зөвхөн их хааны харьяа улсыг тэмдэглэсэн нэр байсан, тэр нь монгол хэлний 'qa'an-u ulus' буюу "хаан улс"-ыг хөрвүүлсэн нэр болохыг баттай мэдэж болж байна. Гэхдээ энэ нь улсын цол мэт албан ёсоор тогтсон нэр томъёо биш байлаа.

Улсын тогтсон цолгүй гэдэг талаараа өрнөдийн бусад хант улсууд ч адилхан. Жишээлбэл, эдүгээ бид Цагадайн хант улс гэдэг нэр томъёог өргөн хэрэглэдэг боловч тухайн үеийн түүхийн сурвалжид голцуу "Цагадай улс" (монгол маягаар Chaghatai ulus, перс маягаар ulus-i Chaghatai) гэж гардаг³⁹. Үүнээс гадна Цагадайн угсааныхны дунд тухайн үеийн захирагчдын нэрээр Алгүгийн улс, Баракийн улс гэх зэргээр тэмдэглэсэн нь ч бий⁴⁰. Энэ нь Кипчакийн хант улс, Эл хант улс зэрэгтэй адил бөгөөд бүгдээр тодорхой хүний нэрийн ард, "тэр, тэрний улс" гэх маягаар нэрлэсэн хэрэг юм. Цаашилбал, Өрнөдийн гурван хант улсаас гадна Дорнодод Чингэс хааны дүү нартаа хуваарилж өгсөн харьяат газрыг мөн л "тэр, тэрний улс" хэмээн нэрлэж байлаа⁴¹. Түүгээр зогсохгүй хаан улсад харьяалагдах доод зэргийн улс байсан тухай дурдсан нь бий бөгөөд тухайлбал Тангадын нутагт байлдаж явсан Хубилайн ач Ананд өөрийн гэсэн улстай байсан гэдэг тэмдэглэл буй⁴². Сүгияама Масааки, Хубилайн захиргааны улс дотор "гурван том улс, хоёр жижиг улс" оршин байсан гэж тэмдэглэсэн⁴³ ба энэ нь нэг улс дотор бас өөр улс оршин байдаг давхцсан бүтцийг харуулж байна гэж хэлж болох юм.

Тухайн үед олон хан (諸王)-гуудын захиргаанд байсан орон нутгууд нь тогтсон нэргүй өөрөөр хэлбэл улсын цолгүй байсныг хятад сурвалжаас ч дам байдлаар тогтоож болно. Тухайлбал, "Юань улсын судар"-т эзэнт гүрний хаа сайгүй тархан суусан Чингисийн удмынхны тухай байсгээд гардаг ба тэднийг хан (諸王), угсаат ван (宗王) гэж нэрлэдэг, тус бүрдээ өөрийн гэсэн улс (部) эзэмшиж байсан тухай тэмдэглэжээ. Жишээ нь, Есөнтөмөр (Yisun Temur, 秦定帝; 1323-28)-ийн үед "Кэбэг, Өзбэг, Абу Саид гурван ханы улс" руу элч илгээсэн тухай тэмдэглэсэн байдаг⁴⁴ ба Кэбэг (怯別, Kebeg), Өзбэг (月思別, Цзбег), Абу Саид (不塞因, Abu Said) гурав бол Төв Ази, Кипчакийн тал нутаг, Баруун Ази дахь Өрнөдийн гурван хант улсын монгол захирагчид юм. Нанхиад сурвалжид гарах 諸王 гэдэг үг нь монгол хэлний kцbegьd (kц'ьd буюу хүүд) хөвүүд хэмээх үгийг хөрвүүлсэн үг ба Чингис хааны удам залгуулсан хөвүүдийг нэрлэсэн нэр байв. Тэгвэл тэдний захирч байсан 部-тай тохирох үгийг монгол хэлнээс хайвал тэр нь даруй "улс" болох биз. Гэхдээ "Юань улсын судар"-т Өрнөдийн гурван хант улсаас гадна нэгд нэггүй тоочих аргагүй олон тооны 部 ба 諸王-ны тухай тэмдэглэжээ. Тиймээс Их Монгол улс нь "諸王" гэж нэрлэдэг Чингэс хааны үр ач нарын захирсан олон тооны улсын бүрдэл гэж үзэж болох ба "Хаан улс" ч бас бусад олон улсаасаа үндсэндээ ялгаагүй байсан гэж үзэж болно.

Цааш шүүмжлэн хэлэлцэхээсээ өмнө бид тухайн үеийн монголчуудад улс гэдэг үг чухам ямар утга учиртай үг байсныг судлан үзье. "Улс" гэдэг ухагдахууны тухай Оросын эрдэмтэн Владимирцов дараах байдлаар тайлбарлажээ.

Эртний монголчуудын хувьд овог, аймаг, ястан зэрэг бүхий л нэгдлүүд нь хан, ноён, тайш,

³⁹ 『부족지』, p.182; 라시드 앓 딘, 『칸의 후예들』, (김호동, 사계절, 2005), p. 28, pp. 215-216, p. 218 등

⁴⁰ 『칸의 후예들』, p.387; Rashid/Rawshan, 1067

⁴¹ 『칭기스 칸기』, p.97.

⁴² 『칸의 후예들』, p.471.

⁴³ 『몽골세계제국』, (임대희, 김장구, 양영우 옮김, 신서원, 1999), pp.198-200.

⁴⁴ 『元史』 卷30 「泰政」, p.673.

баатар зэрэг удирдагч нарт харьяалагддаг гэж үзвээс тэдгээр нь улс “ulus” буюу 百姓-屬領 (narod-vladienie) юм уу эсвэл 百姓-采領 (narod-udel) гэж нэрлэгдэнэ. Жишээлбэл, тайчуудыг ойрын цусан холбоотой гэж үзсэн тохиолдолд тэднийг иргэн, мөн ястан, аймаг гэх зэргээр нэрлэж болох ч яг тэр тайчуудыг бүр тэдний нэг хэсгийг Таргудай Хирилтуг мэтийн удирдагч захиргаандаа оруулсан үед улс буюу 百姓-屬領, дахиад хэлбэл тэрхүү удирдагчийн “улс” болно. Ингэж үзвээс улс гэдэг үгийг хэсэг хугацаанд ч атугай 百姓-采領 гэж орчуулж болох юм. Гэхдээ монголчууд цэвэр нүүдэлчин үндэстний хувьд энэ үгийн утгыг газар нутаг бус хүн ардтай холбож ойлгодог. Үнэндээ улс гэдэг үгийн үндсэн утга нь даруй “хүн ард” юм.⁴⁵

Дахиад хэлбэл, “улс” бол зүгээр л цусан холбоотой бүлэг хүнийг илэрхийлсэн “иргэн” гэдэг үгнээс өөр, тодорхой удирдагчийн дор нэгдсэн улс төрийн нэгжийг заасан үг гэж ойлгож болох ба уг ухагдахуунд “харьяа газар, газар нутаг” бас багтах боловч тэр нь ямагт хоёрдугаар зэрэгт явна. Харин үндсэн утга нь хэзээд “хүн ард” байжээ.

Владимирцовын энэ үзлийг XIII-XIV зууны түүхэн сурвалжаар бататгаж болно. Юуны өмнө “Монголын Нууц Товчоо”-нд Чингис хаан эзэнт улсаа байгуулахаас өмнө Монголын тал нутагт тархай бутархай оршсон олон аймгийг “миний улс” (ulus minu)⁴⁶, “чиний улс” (ulus chinu)⁴⁷, “бутарсан улс” (butaraghsan ulus)⁴⁸, “хураагдсан улс” (quriaghdaghsan ulus)⁴⁹, “дүрвэсэн улс” (dürbegsen ulus)⁵⁰, “олон улс” (olon ulus)⁵¹ гэх зэргээр илэрхийлжээ. Тэдгээр нь “улсын эзэн”-нд захирагдаж, ерөнхийдөө нэгэн цусны хүмүүсээс бүрэлдсэн ч тэдний дунд “харь иргэн” бас байжээ. Чингис хаан дэлхийг байлдан дагуулж, Монголын эзэнт гүрнийг байгуулахдаа үндсэндээ эдгээр цусан холбоогоор холбогдсон овог, аймаг гэсэн нэгж бүхий улсуудыг задлаж, нэгтгэснийхээ дараа өөрийн ураг төрлийхөнд хуваан эзэмшүүлжээ. Чингис хааны хойч үедээ үлдээж өгсөн “Их Монгол улс” нь хааны удмыхан эзэн (ejen) суусан олон тооны улс болж дахин зохион байгуулагдсан авч энэ нь хэн нэг удирдагчийн дор нэгдсэн улс төрийн нэгдэл байсан бөгөөд түүний үндсэн утга нь “ард иргэн” хэвээр тул улс гэдэг үгний үндсэн ухагдахуун нь өөр болсон бус.

Жишээлбэл, Отчигины улсын хожмын хан Тогочар “олон улс, цэргээ захирч” (ulus va lashkar besiybr dbnist) байсан⁵² гэхэд энд гарч буй улс бол газар нутаг гэдэг ухагдахуунд суурилсан хант улс, төр улс гэсэн утга бус түүний захиргаанд орсон ард иргэн олон улс байжээ гэсэн утгатай болно. Мөн Төмөр хааны ээж Хөхчин хатан (Kčkechin Khatun) “Китай ба Нангияс хант улсуудад манай улс тун олон.”⁵³ гэж хэлсэн нь дээрхтэй утга нэг. Тэр эмэгтэйн хэлсэн үг бол Монголын тал нутагт угаас нутаглаж ирсэн нүүдэлчдээс эзэнт улсын иргэд бүрдэж байсан бол одоо байлдан дагуулсан орны иргэд, хятадууд ч бас улсын бүрэлдэхүүнд орсныг үзүүлэх сонин баримт юм. Мэдээж Монголын эзэнт гүрэн, дэлхийг байлдан дагуулсантай холбогдох үзэгдэл бөгөөд улс

⁴⁵ B. Ia. Vladimirtsov, *Obshchestvennyi stroi Mongolov: Mongol'skii kochevoi feodalizm* (Leningrad: Izd. AN SSSR, 1934), p. 97. Cf. 주채혁 역, 『몽골사회제도사』 (대한교과서주식회사, 1990), pp. 166-167.

⁴⁶ 『몽골비사』 164절, 177절, 189절, 유원수의 역주본 (사계절, 2004)-ыг гзнэ гг.

⁴⁷ 『몽골비사』 177절, 245절.

⁴⁸ 『몽골비사』 96절, 104절, 208절.

⁴⁹ 『몽골비사』 73절.

⁵⁰ 『몽골비사』 146절.

⁵¹ 『몽골비사』 190절, 254절, 272절, 280절, 281절.

⁵² 『칭기스 칸기』, p. 91. (Revan Kuşkü 59r.). Сүүлчийн үгийг *dasht* гэж уншиж болох бөгөөд тэгвэл “захирч” бус “эзэмшиж” гэж орчуулсан нь таарамжтай.

⁵³ 『칸의 후예들』, p. 480; Rashid/ Rawshan, p. 957.

гэдэг ухагдахуун өргөжин томорчээ гэж үзэж болох авч, улс нь тодорхой газар нутагт суурилсан төр улс гэдэг ухагдахуун бус харин удирдан захирагчийн харьяат иргэд хэмээн ухаж ойлгосон гэдгээрээ урьдахаас онц өөрчлөгдсөнгүй.

Удирдагч захирагчтай байж сая “улс” гэдэг бүлэг нэгдэл нь оршин тогтнох үндэс суурьтай болно гэдгийг бодох аваас өмнө дурдсан Монголын эзэнт гүрний үеийн олон улс (部), тогтсон нэргүй “тэр, тэрний улс” гэх маягаар нэрлүүлэх болсон, мөн яахаараа дорнодын гурван улсаас гадна олон улс дурдагддаг болохыг ойлгож болно. Тухайлбал, Их Монгол улс бол Их хаан толгойтой, тэгээд Чингисийн удмыхан тус тус захирсан олон тооны улс, тэдгээр нь дахиад дотроо доод зэргийн (下位) улсуудаас бүрдсэн “улсын нийлмэл биет” юм. Их Монгол улсыг бүрдүүлдэг ийм жижиг, дунд хэмжээний улсууд нь үндсэндээ монгол, түрэг угсаат нүүдэлчдийн улс байсан ба байлдан дагуулсан орны иргэд голцуу их хааны мэдэлд захирагддаг байв. Их хааны тушаал юм уу эсвэл томилгоогоор эдгээр улсын захирагч хэн болохыг тогтоож, үе залгамжлуулдаг байжээ. Наад зах нь Мөнх хааны үе хүртэл ингэдэг байсан болов уу. Зүчийн улсыг захирсан Бат, Мөнхийг их хаанд өргөмжлөөд асар их эрх мэдэлтэй болсон хэдий ч Мөнх хаан эзлэгдсэн орос иргэдийг урьдын хэвээр захирсаар байлаа⁵⁴.

Харин Хубилай хаан сууснаар улсын энэ мэт тогтолцоонд тун их өөрчлөлт оруулав. Аригбөхийг цэргийн хүчээр дарж чадахгүй болсон Хубилай өрнө зүгт тогтсон улсуудын удирдагч нарт захирах эрхийг нь найр тавин өгч байж тэднээр өөрийгөө дэмжүүлэх гэсэн байна. Хубилай, Хүлэгү, Алгу нарт элч илгээж, санал тавьсан тухай “Судрын чуулган”-д ийнхүү өгүүлжээ.

*Амударьяа мөрний эргээс Мисирийн хаалга (門)dar хүртэлх [газар дахь] монгол цэрэг ба тажик нутгийг Хүлэгү чи захир ! Алтайн тэргээгээс Амударьяа хүртэлх ил улсыг Алгу чи захир ! Алтайн энтээгээс тэнгис далайн эрэг хүртэлхийг би мэдье.*⁵⁵

Энэ санал бол Зүчийн улсыг эс тооцвол Монголын эзэнт гүрнийг бүхэлд нь гурав хувааж, баруун Азийг захирах эрхийг Хүлэгүд, төв Азийг захирах эрхийг Алгүд өгч, их хаан өөрөө Алтайн нуруунаас зүүн талын нутгийг мэдэлдээ байлгавал сэтгэл ханамжтай болохоо мэдэгдсэн хэрэг байлаа. Хубилай хаан Хүлэгү, Алгу нартай нэгдсэн тул Зүчийн улсын Бэрх тэдний нийтийн дайсан болж тусдаа бие даасан нь зүйн дагуу хэрэг. Хубилайн энэ санал бол одоог хүртэл байлдан дагуулсан орон нутгийг бүхэлд нь ганцаар захирч ирсэн их хааны монополь эрхээс татгалзаж, хангууд тус тусын улсаа толгой даан захирах эрх олгосныг харуулна. Байлдан дагуулсан нутаг орноо захирах эрхийг хангуудад олгосон нь хант улсын нийгэм, эдийн засгийн бие даасан үндэс суурийг бататгасан хэрэг, мөн тэдний захирсан улсыг бие даах боломжтой болгож өгчээ. Тэгвэл Хубилайн энэ санал, эцэстээ Монголын эзэнт гүрнийг задруулж, “дөрвөн хант улсын тогтолцоо”-г бий болгосон хэрэг үү. Одоо энэ асуудлыг нягтлан үзье.

IV. Эзэнт гүрний нэгдмэл шинж

Аригбөхийг бууж өгсний дараахан 1264 оны сүүлийн хагаст Хубилай өрнөдийн гурван хант улсын удирдагч Бэрх, Хүлэгү, Алагү нарт элч илгээн өөрийн засаглалыг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэхийн тулд хурилдай зарлан урьжээ. Гэвч түүний төлөвлөгөө бүтсэнгүй. Учир нь Хүлэгү 1265 онд 49-тэйдээ нас барж, Бэрх 1266 онд өөд болсон ба Алагү мөн ойролцоо үед

⁵⁴ Энэ талаар Т. А. Allsen-ы *Mongol Imperialism* (Berkeley: University of California Press, 1987), pp.134-143-ыг үзнэ үү.

⁵⁵ 『칸의 후예들』, p 382.

1265-66 онд нас баржээ.⁵⁶ Тэдний үхлийн тухай мэдээ аваад Хубилайн хэрхсэн талаар “Судрын чуулган”-д ингэж бичжээ.

Тэдний үхсэн тухай мэдээ хаантанд хүрэхүй дор [Хубилай] Хүлэгүгийн том хөвүүн Авгыг тохоон эцгийн ор суулгаж, Иран орны монгол, тажикуудыг захируулахаар томилсон ба Бэрхийн улсыг Мөнх Төмөрт соёрхов. Алгу бас ужиг өвчтэй болж, хуралдайд оролцож чадсангүй, тэр бас ертөнцийн мөнх бусыг үзүүлэв. Харин Ургана хатан, эмир нартайгаа зөвлөлдөн хөвүүн Мубарак Шахыг Алгу-гийн ор суулгав. Гэтэл Цагадайн хөвүүн Мүтүгэн түүний хөвүүн Ийсүн Дува-гийн хөвүүн Борог хаанд бадрал айлтгасан нь : Мубарак Шах яагаад миний авга ах Алгугийн ор сууж байгаа билээ? Хэрэв намайг авгын ор суулгах зарлиг буулгах аваас би алба хашиж, захирагдахад бэлэн байна! гэсэн байна. Хаан түүнд зарлиг буулгаж Мубарак шахыг торнитол Борогоор улсыг захируулав. [Тийм учир] тэр ирж түүний суурийг булаан авлаа.⁵⁷ (Онцлох хэсгийг доогуур нь зурж тэмдэглэв.)

Эндээс үзэхэд Хубилай, хэдийгээр Хүлэгү, Алгу нарт баруун болон төв Азийг захирах эрхийг найр тавьсан боловч өрнөдийн хан улсуудын захирагчийг томилох хэрэгт оролцож, их хааны эрхээ хэрэгжүүлсээр байжээ. Мэдээжээр, хааны энэ мэт эрх мэдэл хэр зэрэг бодитой хэрэгжиж байсан талаар эргэлзэж болох юм. Ялангуяа Хубилайтай тийм ч найрсаг харилцаатай байгаагүй Зүчийн улсад удирдагчийг томилоход тоймтой нөлөөлж чадаагүй гэж таамаглаж байна. Тэрбээр Зүчийн улсын төрийн хэрэгт шууд оролцож, Мөнх Төмөрөөр төр бариулсан гэж хэлэхэд хэцүү боловч дээрх ишлэлээс үзэхэд Хубилай хаанд Бэрх үхэж, Мөнх Төмөр ор суусныг Зүчийн улсаас мэдэгдэхэд Хубилай түүнийг нь хүлээн зөвшөөрсөн зарлиг буулгажээ хэмээн таамаглахад хүргэж байна. Аригбөхийг дэмжсэн Зүчийн улсын Мөнх Төмөрийг Хубилай хаанд тэрсэлдэх санаа агуулж байсан гэж үзсэн ч, их хааны сууринд баттай суусан Хубилайн зарлиг л Мөнх Төмөрийг Зүчийн улсын шинэ удирдагч болохыг эзэнт гүрний хэмжээнд албан ёсоор зөвшөөрүүлэх байв.

Тэгвэл Авгын хувьд хэрхсэн бол. Түүнийг угаас Хүлэгү өөрийн үе залгамжлагч гэж заан нэрлэсэн байлаа. Өөд болсон аавынхаа сууринд суу гэж их сайд нарыг ятгахад тэрбээр, “Хубилай хаан миний ах. Их хааны зарлиг буугаагүй байхад би хэрхэн аавын сууринд суух билээ” гэж татгалзсан ч, эцэстээ сайд нарынхаа ятгаснаар 1265 оны 6-р сарын 19-нд Азербайжанд хан сууринд суужээ.⁵⁸ Түүнээс хойш “далд” эрх мэдэлтэй байсаар Хубилай өөрийг нь хан болгосон тухай зарлиг буулгатай таван жил хүлээсэн байна.⁵⁹ Эл хан (il khan) гэдэг цолыг их хаанаар хүлээн зөвшөөрүүлж байж Авгын засаглал хууль ёсны болох учраас тийнхүү Хубилайн зарлигийг хүлээхээс өөр аргагүй байлаа.

Борогийн хувьд гэвэл Алгуг үхсэний дараа түүнийг хан болгох их хааны зарлиг буусан ч гэсэн Ургана хатан ба Мубарак шахын талыхан хүч нөлөөгөө хэдийн бэхжүүлчихсэн үе тул тэднийг амархан зайлуулчихаж чадаагүй ажээ. Тиймээс хэсэг хугацаанд аясыг дагаж байгаад Мубарак Шахын талын их ноёд, жанжидыг өөрийн талд элсүүлсний дараа эрх мэдлийг атгаж

⁵⁶ Тэдний нас барсан оны талаар G. Vernadsky, *The Mongols and Russia* (New Haven: Yale University Press, 1953), p.163; J. A. Boyle ed, *The Cambridge History of Iran*, vol. 5: *The Saljug and Mongol Periods* (Cambridge: Cambridge University Press, 1968), p.354; M. Biran, *Qaidu and the Rise of the Independent Mongol State* (Richmond Surrey: Curzon Press, 1997) p.23 зэргийг үзнэ үү.

⁵⁷ 『칸의 후예들』, p 396.

⁵⁸ Rashid/ Rawshan, p.1089; W. M. Thackston tr: *Jami'u'l-tawarikh: Compendium of Chronicles*, vol. 3 (Cambridge, MA., 1998), p.517

⁵⁹ T. A. Allsen, *Culture and Conquest in Mongol Eurasia* (Cambridge: Cambridge University Press, 2001), p.25.

чадсан байна.⁶⁰

Ингэж үзвэл Хубилай хааны зарлиг нь өрнөдийн гурван хант улсад яг адилхан үйлчлээгүй гэж хэлж болно. Зүчийн улсын хувьд ердөө бэлэг тэмдгийн шинж чанартай байсан бол Хүлэгүгийн улсад хууль ёсоор хан болох гол хүчин зүйл болж, харин Цагадайн улсад нэг ханыг нөгөөгөөр сольжээ. Хүлэгүгийн улсад Авгыг үхсэний дараа хан ширээний төлөө тэмцэл өрнөж, Авгын хүү Аргун (Arghun) 1284 оны 8-р сард хан болсон ба 1286 оны 1-р сард Хубилайн зарлиг бичиг иржээ. Аргуныг хан болсноос хойш 17 сарын дараа зарлиг ирсэн гэсэн үг тул Хубилай, хан болохоос нь өмнө Аргуныг дэмжиж байсан хэмээн таамаглал бий.⁶¹ Энэ үнэн бол Хубилай нь Хүлэгүгийн улсын хан ширээ залгах тэмцэлд тун их нөлөөлсөн гэсэн үг болно.

Түүгээр зогсохгүй эзэнт гүрний хэмжээнд зөвхөн их хаан ганц хүнийг л "хаан" гэж цоллож болдог ба бусдыг нь "хан" гэж цоллодог байсан нь анхаарал татууштай. Жишээлбэл, Дорнодын гурван хант улсад хааны зарлигаас өөр эрх мэдлийн "булаг" эрж олох гэсэн оролдлого гарч байсан, тэдгээр улсын дотоод хэрэгт хаан оролцдоггүй хэдий ч захирагчид нь өөрсдийгөө хан гэж нэрлэхээс бус хаан гэдэг цол хэрэглэж байсангүй.⁶²

Хүлэгү ба түүний залгамжлагчид, "[их хаанд] захирагдах хан" гэдэг утгатай "эл хан" гэдэг цолтой байсныг нийтээр мэдэх⁶³ ба харин Мамлюкийн улсын султан Ан Насир Мухаммед ибн Калаун (an-Nasir Muhammad b. Qalawun), Зүчийн улсын удирдагч Үзбэг (Цзбег, 1313-1341)-т илгээсэн албан захидалдаа түүнийг "эл хан" гэж нэрлэсэн нь⁶⁴ зөвхөн Хүлэгү-гийн улсын удирдагчдыг л эл хан гэж цоллож байгаагүй, их хаанд захирагддаг бусад хан нарын бүгдийнх нь цол байсан байх боломжтойг харуулж байна.

Түүгээр зогсохгүй нанхиад сурвалжид их хааны зарлигийг л '聖旨' гэж нэрлээд, хан, хатан, сайд түшмэдийн зарлиг бичгийг '令旨', '旨', '旨', гэх зэргээр нэрлэсэн нь анхааруштай. Уйгар, дөрвөлжин бичгээр бичсэн монгол хэлний бичгийн дурсгалд ч мөн ийн ялгамжтай тэмдэглэж, их хааны зарлигийг л "зарлиг (jarliq, 勅令)" гээд бусдыг нь бүгдийг үг (üge, үг хэл) гэж нэрлэжээ.⁶⁵ Мэдээжээр, цаг хугацаа улиран өнгөрөхийн хэрээр энэ ялгаа бүдгэрчээ. Мамлюкын улсын түүхч Аль Үмари (al-'Umarī)-гийн бичигт ханы зарлиг бичгийг хэрхэн нэрлэх талаар Цагадайн улсынхан ба Их хааны талынхан хэрхэн маргалдсан тухай гардаг. Түүнд их хааны зарлигаар умард хязгаарыг сахин суусан Тогачи чинсан (Togachi Chingsang), Цагадайн улсын захирагч Есөнбух (Esen Buqa, 1310-1318)-ын элчид хандаж, хан хүнд таарах '命令' (farmvn) юм уу эсвэл '令旨' (lingil)-г бус харин '勅令' (jarliq) гэдэг үг хэрэглэснийг шүүмжилжээ.⁶⁶ Мэдээж хэрэг зарлиг бичгийг хэрхэн нэрлэх талаарх энэ маргаан нь их хааны эрх мэдэл ганхаж эхэлснийг харуулах авч их хаан ба ханы улс төрийн байр суурь ялгаатай талаарх үзэл ойлголт наад зах нь XIV зууны эхээр гэхэд урьдын хэвээр оршсоор байсныг үзүүлнэ.

⁶⁰ J. A. Boyle tr. *The Successors of Genghis Khan* (New York: Columbia University Press, 1971), p. 139; 劉迎勝, 『西北民族史與察合台汗國史研究』(南京: 南京大學出版社, 1994), pp. 146-148.

⁶¹ Allsen, *Culture and Conquest in Mongol Eurasia*, pp. 27-28.

⁶² "Хан" ба "хаан" цолын ялгааны тухай I. de Rachewiltz, "Qan. Qa'an and the Seal of Guyug, Documenta Barbarorum. Festschrift für Walther Heissig zum 70. Geburtstag (Wiesbaden: Otto Harrassowitz, 1983), pp. 272-281; 杉山正明, 『モンゴル帝國と大元ウルス』 pp. 382-384. зэргийг үзнэ үү.

⁶³ "Эл хан" гэдэг үгийн утга, гарлын талаар R. Amitai-Priess, *Mongols and Mamluks* (Cambridge: Cambridge University Press, 1995), p. 14-ыг үзнэ үү.

⁶⁴ Tizengauzen, *Sbornik*, tom. 1, p. 334, p. 343.

⁶⁵ 杉山正明, 『フビライの挑戦』(東京, 1995), pp. 119-12

⁶⁶ K. Lech ed. and tr., *Das mongolische Weltreich: al-Umaros Darstellung der mongolischen Reiche in seinem Werk Masalik al-abşer fi l-mamalik al-amşer* (Wiesbaden, 1968), pp. 205-206

Монголын эзэнт гүрэн нь улс төрийн нэг дэг журам дор байсан, өөрөөр хэлбэл тухайн үеийн монголчууд эзэнт гүрний нэгдмэл шинжийн талаар үзэл ойлголтгүй байсан бол доод улсын удирдагчдын залгамж халааны асуудал, хаан ба хан цолны ялгаа, зарлиг бичгийг ялгамжилсан нэр зэргийг тайлбарлахад бэрх юм. Тэгвэл нэгдмэл шинжийн талаарх үзэл ойлголт хаанаас гарсан, хэрхэн хадгалагдсан юм бол. Юун түрүүнд эзэнт гүрний доторх олон улсын захирагчид бүгд Чингэс хааны үр удам тул нэг гэр бүл - алтан ураг ‘黃金氏族’ (altan urug)-т харьяалагдана гэдэг ухамсарт тулгуурлажээ. Тэр үеийн монголчууд нэгэн овгийн гишүүдээ ‘aqa de’ü’ буюу ах ба дүү нар гэж нэрлэдэг байлаа.⁶⁷ “Судрын чуулган”-д түргээр ‘aqa wa ini’ гэж шууд орчуулсан энэ үг олон гарна. Жишээлбэл: “Миний ураг төрөл дундаас хэн нэг нь хууль зөрчвөөс бүх ах дүү нартайгаа хэлэлцэн зөвлөлдөхгүйгээр түүнийг хөнөөж үл болно” гэдэг Чингис хааны зарлигт гарч буй “ах дүү нар” бол үнэндээ нэг удмыхныг хэлж буй хэрэг.⁶⁸

Чингис хааныг өөд болсноос хойш ч энэ үзэл ойлголт хэвээр байж Монголын эзэнт гүрэн болоод олон улсыг захирсан түүний удмыхан бие биесээ “ах дүүгийн хэлхээ”-тэй гэж үзэн их хааны үе залгамжлагчийг тогтоох зэрэг эзэнт гүрний чухал хэргийг хэлэлцэх хуралдайг “ах ба дүү нар”-ын чуулган гэж үздэг байжээ. Тухайлбал, бууж өгсөн Аригбөхийн асуудлыг хэлэлцэхээр Хубилай Хүлэгүд элч илгээн саналыг нь асуухад Хүлэгү “олон ах дүү нартай хэлэлцэн шийдвэрлэдэг журмаараа болох хэрэгтэй” гээд “ах дүү” нарыг хуралдайд ирүүлэн Аригбөхийг цаазлах эсэхийг шийдвэрлэе гэж хариулсан ба Алгу, Бэрх хоёр ч мөн адил хариу илгээжээ.⁶⁹ Өгөдэй хааныг өөд болсны дараа “олны ах” Бат хуралдайд оролцоогүй тул “гурван жилийн турш хаан сууринд хэн суухыг шийдэж чадаагүй” гэсэн тэмдэглэлийг⁷⁰ ч мөн ингэж ойлгож болох юм.

Энд “ах” гэдэг үгийг нэгдүгээрт “ах” гэдэг шууд утгаар нь ойлгож болох авч тухайн үед ах төдийгүй нагац, эр нөхрийг хүртэл ах гэж дуудаж байсныг харуулах баримт олон бий. Тиймээс “ах” гэдэг үгийн ураг төрлийн холбоотой ахмад хүнийг дуудах утгын хүрээ тэлж, нэгэн төрлийн “хүндэтгэлийн нэр” болон хэрэглэгдэх болжээ.⁷¹ Тэгвэл Батыг “ах” гэж дуудах үед ураг төрлийн “ах” гэдэг утгаас гадна “ахмад хүн”, “хүндэт хүн” гэсэн утгыг давхар агуулдаг гэж хэлж болно.

Харин тухайн үеийн түүхийн сурвалжид их хааныг “ах” гэж нэрлэсэн олон жишээ бий. Тухайлбал: Мөнхийг хаан суусны дараа түүний эсрэг босох гэсэн Өгөдэйн удмын Хожа (Khwaǰa)-д “Мөнх хаан бидний ах, ааваас минь өөрцгүй” гэж гэргий нь хориглон хэлсэн⁷² болон Хубилай төрсөн ах Мөнхийн талаар “Ах минь морины нуруун дээр дайтаж явахад би хэрхэн гэрийн мухар сахиж суух билээ” гэсэн⁷³ зэрэг болно. Иранд Хүлэгүг үхсэний дараа түүний үе залгамжилсан Авга нь 1265 онд “Миний ах бол Хубилай хаан билээ. Түүний зарлиг үгүй хэрхэн их сууринд суух билээ” гэж хэлсэн⁷⁴, мөн Авгыг үхсэний дараа Авгын хүү Аргуныг дэмжигч Бух (Buqa) гэдэг хүн Хубилайг “Ертөнцийн их хаан, Чингис хааны бүх ураг (ürüg)-ийн ‘ах’ болсон хаан” гэжээ.⁷⁵ Түүгээр зогсохгүй Мөнх хаан Өмнөд Сүн улсыг дайлах хэрэгт өөрийн биеэр

⁶⁷ Жишээлбэл, “Монголын Нууц Товчоо”-ны 74, 76, 77, 82, 94-р зүйлд тайчууд овгийг тайчууд ах дүү нар (Taiyici’ud aga de’ü) гэсэн бол 213-р зүйлд баяуд овгийг баяуд ах дүү нар (Baya’ud aga de’ü) гэжээ.

⁶⁸ 『부족지』, p 137.

⁶⁹ 『칸의 후예들』, p 395.

⁷⁰ 『칸의 후예들』, p 191.

⁷¹ F. W. Cleaves, “Aga Minu,” *Harvard Journal of Asiatic Studies*, vol. 24(1962-63), pp.64-81

⁷² 『칸의 후예들』, p 329.

⁷³ 『칸의 후예들』, p 344.

⁷⁴ Rashid/ Rawshan, vol. 2, p.1059; Thackston tr. Jami’u’t-tawarikh: Compendium of Chronicles, vol 3, p.517

⁷⁵ Rashid/ Rawshan, vol. 2, p.1145; Thackston tr. Jami’u’t-tawarikh: Compendium of Chronicles, vol 3, p.558

оролцох шийдвэр гаргаад “Өвөө, аав, ах нар минь буюу өнгөрсөн үеийн хаадууд бүгд нэг нэг их үйл бүтээсэн... би ч бас өөрийн биеэр их цэргээ удирдан дайлаар мордож...” гэж хэлсэн⁷⁶ зэрэг нь их хаан, өөрийн өмнөх үеийн хаадыг “ах” гэж нэрлэж байсныг гэрчилнэ. Энэчлэн Монголын эзэнт гүрний хаан нь ноёлогч бүлгийг бүрдүүлдэг Чингис хааны ураг төрлийхний хувьд зөвхөн төрийн эрх атгасан хаан төдий бус, алтан ургийхны “ах”, “ахмад хүн” болохын зэрэгцээ “хүндэт хүн” гэж ойлгогдож байжээ.

Мэдээжээр зөвхөн эзэнт гүрнийг удирдан захирагч их хааныг л ганцааранг “ах” гэж дуудаж байсангүй. “Ах” гэдэг үг бол өгүүлэгч, эсрэг этгээдээ нэрлэх нэр тул олон улсын захирагч нар бие биесийг ах гэж дуудаж байжээ. Жишээлбэл, 1270 онд Цагадайн удмын Барак, Хүрасань нутаг руу дайлаар яваад үхэхэд түүний удмын Мубарак Шах, Чүбэй, Кабан нарын хан нар цуглаж, “Өнөөдрөөс Хайду ах бидний ах боллоо. Ямар ч зарлиг буулгасан бид дагана” хэмээн тангарагласан удаатай.⁷⁷ Мөн 1312 оны өвөл Зүчийн улсын Үзбэг хан Хүлэгүгийн улсын Өлзийтөд элч илгээж “Та ах, би дүү тань билээ. Бид хоорондоо эвтэй найртай байх эртний уламжлалтай” гэж хэлүүлэн найрамдах санал тавьж байжээ.⁷⁸

Олон улсын удирдагчид бүгдээр өөрсдийгөө Чингис хааны үр хойч, нэг угсааны “ах дүүс” гэж үздэг энэ үзэл, Монголын эзэнт гүрний дотоод харилцааг тодорхойлоод зогсохгүй эзэнт гүрний гадаад харилцаанд ч илрэлээ олдог. Тухайлбал, Хүлэгүгийн улсын эзэн Өлзийт, 1305 онд Францын хаан 4-р Флиппд илгээсэн захидалд:

Муу хүний хорон үгнээс болж, ах дүүс холджээ. Эдүгээ тэнгэрийн ивээлээр Төмөр хаан, Тогтоа, Чапар, Тү-а тэргүүтэй бид, Чингис хааны угсааныхан 45 жилийн өмнөөс одоог хүртэл тэмцэлдэн муудалцаж явснаа одоо тэнгэрийн өршөөлөөр ах дүүс бүгдээр эвтэй найртай болов. Наран ургах Нангиясын газраас Талу (Talu) далайг хүртэлх улс барилдаж (ulus barildiju), өртөөгөөр холболоо. “Бидний дундаас хэн нь ч атугай өөр бодол бодох аваас бүгдээр нийлж, түүнтэй тэмцье!” гэж андгайлав.⁷⁹

Энэ захидал, 1301 онд Хайдуг үхсэний дараа 1303 оны намар түүний хүү Чапар, Цагадайн удмын Тү-а нар их хаанд элч илгээж, найрамдахыг хүссэнээр удаан хугацаанд үргэлжилсэн дотоодын дайн дуусч, “Дорнодод их энх” тогтсоныг мэдэгдсэн агуулгатай. Захидлын дунд хэсэгт дурдсан Төмөр хаан (成宗) бол Хубилай хааны ач, залгамжлагч нь бөгөөд Тогтоа нь Зүчийн улсын захирагч тул Чингис хааны дөрвөн хүүгийн удмыг бүгдийг төлөөлж чадахуйц төлөөлөгч гэж хэлж болно. Өлзийт хан захидалдаа эднийг бүгдийг “Чингис хааны ураг (Chinggis Qaghan-u urughud)” гээд “ах дүү (ага degü)” гэж илэрхийлжээ. Өөрөөр хэлбэл энэ захидал, наран ургах зүүн зүгээс наран шингэх баруун зүг хүртэлх өргөн уудам нутгийг эзлэсэн Монголын эзэнт гүрний доторхи улсуудыг захирдаг захирагчид нь бүгд Чингис хааны үр хойч тул нэгэн ураг төрлийн бүлэгт багтана гэдэг язгууртны ухамсрыг тодорхой харуулж байна.

Олон улсын захирагчид бүгд нэгэн адил “алтан ураг”-т багтах бөгөөд нэгэн ураг төрлийхний “ах” болох хаан оройтой бүрэлдэн тогтсон хамтын ухамсар нь эдийн засгийн талд ч илрэлээ олжээ. Их хаан жил бүр хангуудад хувааж өгдөг бэлэг бол түүний тодорхой жишээ юм. “Юань улсын судар”-ын 95-р дэвтэрийн “Хүнс, эдийн ойллого (食貨志)”-ын “歲賜.篇”-д “Хан, хатан,

⁷⁶ 『칸의 후예들』, p 340.

⁷⁷ Rashid/ Rawshan, vol. 2, p.1145; Thackston tr. Jami'u'l-tawarikh: Compendium of Chronicles, vol 3, p.535

⁷⁸ Muhammad Qashani, Terikhi-i Uljeitü (Muhin Hambly ed., Tehran, 1969), p.146

⁷⁹ A. Mostaert, Les Lettres de 1289 et 1305 des ilkhan Arghun et Uljeitü à Philippe le Bel (Cambridge: Harvard University Press, 1962), pp.17-54; 金浩東, pp.267-268

гүнж нарт идэх хоол, газар хувааж өгсөн” гээд тэдэнд хувааж өгсөн газраас хураадаг гувчуурын хэмжээг тодорхой заасан байхын зэрэгцээ гувчуур татагсдын нэрийн жагсаалтад Хубилайн ураг төрлийхөн төдийгүй Чингис хааны дөрвөн дүү, дөрвөн хүүгийн гэр бүлд харьяалагдах хүмүүсийн нэр байна.⁸⁰ Хубилай, түүгээр зогсохгүй Аригбөхийн талыханд ч хувь олгож, Аригбөхийг бууж өгсний дараа өөртөө захирагдахаас татгалзсан Хайдуд хүртэл хувь газар өгчээ.⁸¹ Харин хаан хувь хишиг болгон газар өгөх нь Хаан улсын байлдан дагуулсан дайны олзыг шударга хуваарилах үзэл дээр суурилж байв. Бусад улс ч бас байлдан дагуулалт хийж байсан тул хангууд нь их хаан болоод бусадтайгаа дайны олзноосоо хуваалцах үүрэг хүлээж байлаа. 1265 онд Масуд Бэк, Хайду Барак нарын төлөөний хүний хувиар Хүлэгүгийн улсад очиж, тэдний үе залган эзэмшиж ирсэн “世襲封邑(injū-hā)” газрын талаар санхүүгийн тайлан тавихыг шаардсан гэх, мөн ойролцоо цаг үед Хубилай, Сартаг ба Абдул Рахман (*Abd ar-Rahmān) нарыг Хүлэгү-гийн улсад илгээж “санхүүгийн хэргийг шийдүүлсэн” зэрэг нь нотолж байна.⁸²

Гэхдээ алтан ургийхны хамтын ухамсарт суурилсан эзэнт гүрний нэгдмэл шинж аажмаар сулрахаас өөр аргагүй байлаа. Тэр нь цаг хугацаа өнгөрөхийн хэрээр бүдгэрдэг нэг цусан төрөлд багтах аа ухамсарлах ухамсар, улсуудын хоорондх улс төр, газар нутгийн талаарх эрх ашгийн зөрчилдөөн, эзлэгдсэн улс үндэстний соёлын нөлөө зэрэг олон төрлийн учир шалтгаанаас үүдэлтэй. Ингэсээр Төв Азид Өгөдэйн угсааны Хайду, Цагадайн улсын төрийн эрхийг атгаад их хааныг эсэргүүцэн босч, түүний улмаас Төв Азийн их хэмжээний газар нутаг их хааны мэдлээс гарахад хүрнэ. Мөн баруун Азийн монгол хангууд аажмаар өөрсдийн эрх мэдлийг их хааны зарлигаар баталгаажуулах бус харин шинээр хүлээн авсан лалын шашнаар баталгаажуулах оролдлого хийж эхлэсэн байна. Аргуныг залган гарч ирсэн Гэйхату (Geikhatu, 1291-95)-гийн үед “эл хан” гэдэг цолыг хэрэглэхээ больж, Газаны үед лалын шашинд ормогц падишах (pvdishah) гэдэг цол хэрэглэж бие даасан эрх мэдэлтэй гэдгээ төвийлгөх болжээ.⁸³

Мөн Зүчийн улсын газар нутгаас олдсон гэрэгэнүүд нь тэдгээр захирагчид хэдийгээр өөрсдийгөө “хаан” гэж цоллоогүй боловч зөвхөн хааны хэрэглэх ёстой “зарлиг” гэдэг үгийг хэрэглэж эхлэснийг харуулна. Тухайлбал, Тогтоа Үзбэг, Абдулла-гийн нэрээр үйлдсэн гэрэгэний “Мөнх тэнгэрийн хүчин дор ... ивээлээр” гэдэг толгойн үгийг залгаад “Тогтоагийн зарлиг”, “Үзбэгийн зарлиг”, “Абдуллагийн зарлиг” гэдэг үг гарна.⁸⁴

Ингэж үзвэл Хубилайн засаглалаас хойш баруун зүгийн улсуудын улс төр, эдийн засгийн бие даасан шинж аажмаар нэмэгдэж, нэгэн цусан төрлийхөн гэдэг үзэл ухамсар бүдгэрэхийн хэрээр эзэнт гүрний нэгдмэл шинж гэдэг ухагдахуун ч мөн сулрахаас өөр аргагүй байлаа. Тэглээ ч гэсэн, нэгдмэл эзэнт гүрэн нэгэн үе хэд хэдэн “хант улс” болж задраад, улмаар “тусгаар тогтносон” хэдэн улсууд бие биеийн өөдөөс сөргөлдөн зогссон мэтээр үздэг урьдны ташаа үзлийг зөв гольдролд нь оруулах цаг болжээ. Яагаад гэвэл бидний “нэгдсэн үе” гэж нэрлэдэг цаг үед ч Монголын эзэнт гүрэн нь олон тооны улсын нэгдмэл цогц байсан бөгөөд “задралын үе” гэж нэрлэдэг цаг үед ч

⁸⁰ 『元史』卷95 「食貨3, pp.2411-2447.

⁸¹ M. Biran, *Qaidu and the Rise of the Independent Mongol state*, p.22.

⁸² Allsen, *Culture and Conquest in Mongol Eurasia*, p.49; 『부족지』 pp.295, 323.

⁸³ T. A. Allsen, “Changing Forms of Legitimation in Mongol Iran,” *Rulers from the Steppes: State Formation on the Eurasian Periphery* (ed. Gary Seaman and Daniel Marks, Los Angeles: University of Southern California Press, 1991), pp.229-232. “Эл хан” цолын талаар Amitai-Preiss, *Mongols and Mamluks*, pp.13-14; “Evidence for the Early Use of the Title Ilkhan among the Mongols,” *Royal of the Royal Asiatic Society*, 3rd series, vol. 1, pt. 3(1991), pp.353-361 зэргийг үзнэ үү.

⁸⁴ Ligeti, *Monuments préclassiques*, vol 1, pp.284-287

“Их Монгол улс”-ын ноёлогч давхаргыхан нэгдмэл шинжээ хадгалсаар байсныг нотлох баримт хангалттай бий.

V. Дүгнэлт

Дээр өгүүлсэн дүгнэлтүүдийг нэгтгэн авч үзье.

1. ‘大元’ нь “Их Монгол улс”-ын нанхиад маягийн нэр бөгөөд түүнээс өмнө ‘大朝’ гэх мэт хэдэн янзаар орчуулсныг жигдлэн нэг мөр болгосон нь тэр юм. Тиймээс энэ бол бидний 大朝 гэж нэрлэж байсан Хятад төвт улс буюу “Их Монгол улс”-ын залгамж улс биш. Мөн нанхиад маягийн нэр тул Корйё, Аннам зэрэг ханз бичгийн соёлтой улсуудад л хэрэглэж байжээ.
2. Нөгөө талаар хань үндэстнүүд Их Юань (大元)-ийг Хань, Тан, Сүн улсын халаа, Хятадын нэгэн хаант улс гэдэг үзэн бичиж тэмдэглэж ирсэн тул тухайн үеийн нанхиад сурвалжид түшиглэн хийсэн судлагаанд ч мөн 大元 –ыг 大朝 гэж үзэхээс өөр аргагүй юм. Харин хань үндэстнээс бусад үндэстнүүд “Хятад”-ыг нэгэн бүхэл гэж үзэлгүй “Китай” юм уу эсвэл “Манж” зэрэг олон янзын газар нутгийн нэг гэж ойлгож байжээ.
3. Бидний одоог хүртэл 大朝 гэж нэрлэж ирсэн газар нутгийг монголчууд болон персүүд “Хаан улс” гэж нэрлэж иржээ. Сүүлийн үед зарим эрдэмтэд “Их Юань улс” гэж нэрлэж байгаа нь зөв биш гэж хэлж болно. “Хаан улс” гэдэг нэр нь бусад хангуудын газар нутгийг “тэр тэрний улс” хэмээн нэрээр нь нэрлэж ирсэнтэй адил зүйл бөгөөд Монголын эзэнт гүрэн нь олон тооны улсын нэгдмэл цогц гэдгийг харуулах баталгаа ч болно.
4. Улсуудын нэгдэл болох Монголын эзэнт гүрнийг хаан оройлон захирдаг, түүний ийм дээд эрх мэдлийг улсуудын захирагчид хүлээн зөвшөөрнө. Их хаан ганцаар хаан цол, зарлиг гэдэг үг хэрэглэх эрхтэй ба мөн доод улсуудын захирагч нарын үе залгамжлалын асуудалд оролцдог байжээ. Үүнийг Монголын эзэнт гүрний нэгдмэл шинжийг харуулах тэмдэг гэж үзэж байгаа бөгөөд түүний нөгөө талд эзэнт гүрний ноёлогч давхаргыг бүрдүүлж байсан Чингис хааны үр хойч, тухайлбал алтан ургийнхны “хамтын ухамсар” оршиж байлаа. Ийм нийтийн буюу нэгэн төрөл садан гэдэг үзэл бодолд тулгуурлан их хааныг ах, ахмад, хүндэт хүн гэсэн олон давхар утга бүхий “ах” гэдэг нэрээр нэрлэж байв. Тэгвэл “хаан” нь эзэнт гүрний захирагч болохын зэрэгцээ ноёлогч бүлгийн “ах” гэдэг хоёрдмол дүрийг нэг дор агуулж байлаа гэж болох юм. Гэвч цаг хугацаа өнгөрөхийн хэрээр энэ мэт нэгдмэл шинж аажмаар суларч, эзэнт гүрний дээд захирагч мөн “ах” болох их хааны эрх мэдэл ганхаж эхлэжээ.

Байлдан дагуулагч Төмөр 1405 онд Мин улсыг байлдан дагуулахаар хөдлөх үед түүний зорилго нь “Хятад” бус харин “ulugh yurt” байлаа.⁸⁵ Энэ бол түрэг үг бөгөөд монголоор их улс гэсэн үг. Төмөрийн улсад их хааны газар нутгийг тэгж нэрлэж байжээ. Өөрөөр хэлбэл, их аян дайн хийсний эцэст урьдны Хүлэгү, Зүчи, Цагадайн улсын газар нутгийг бүрэн эзэлж авсан Төмөр одоо “их улс”-ыг эзлэснээр хуучин “Их Монгол улс”-ын сүр хүчийг дахин сэргээхийг зорьсон бололтой. Түүгээр зогсохгүй Монголын уугуул нутагт Чингисийн удмын Батмөнхыг

⁸⁵ Nizem ad-Don Shemī, *Zafar-nama* (F. Tauer ed.; Praha, 1937), p.12

1470 онд “Даян улсыг эзлэх болтугай” хэмээн “Даян хаан” гэж цоллосон⁸⁶ бөгөөд энд “даян” гэдэг нь “Dai Цн”-тай адил гэдгийг хэлэх нь илүүц хэрэг болох ба тэрбээр Хятадын захирагч болохыг бус 大元=Их Монгол улс-ын хаан болохыг хүссэн хэрэг байлаа. Эдгээр жишээнүүд нь бидэнд Монголын эзэнт гүрний нэгдмэл шинжийн талаар хэр урт удаан хугацаанд мартахгүй санагалзсаар байсныг харуулах түүхэн баримтууд юм.

1260 оны орчим нэгдсэн эзэнт гүрэн “дөрвөн хант улс”-ын тогтолцоонд орж өөрчлөгдсөн гэдэг хуучин ойлголтыг буурь суурьтай олон талаас нь шүүж тунгаан, дахиж судлах шаардлагатай байна. Эзэнт гүрний задралын талаарх үзэл нь Монголын эзэнт гүрний түүхийн судлагааг газар нутаг бүрээр ангилан судлахад хүргэж, бүхэлд нь нэг зүйл гэж харах боломжийг хааж байна. Тийм ч учраас Монголын эзэнт гүрний судлагааг ч бас Хубилайн засаглалаас хойш хант улс тус бүрээр нь судлах хэлбэрээр голлон хийж ирлээ. Эзэнт гүрнийг бүхэлд нь харж, улс төр, эдийн засаг, соёлын харилцаа холбоог нь тодруулахаар хийсэн сүүлийн үеийн зарим судлагааг⁸⁷ өндөр үнэлмээр байна. Цаашид Монголын эзэнт гүрний түүхийн судлагааг хийхдээ хуучин хэлбэрээр, өөрөөр хэлбэл эзэнт гүрэн задарсан гэдэг хуучин үзлээс ангижрах хэрэгтэй байгаа бөгөөд асуудлыг шинээр дэвшүүлж, олон эх сурвалжийг нэгтгэн судласнаар шинэ гарц нээх цаг болжээ.

Түхүүр үг : Монголын эзэнт гүрэн (Mongol Empire), Их Юань (Dai Цн), 大朝 (Yuan Dynasty), Их Монгол улс (Yeke Mongghol Ulus), Хубилай (Qubilai)

The Mongol Empire and ‘Da Yuan’

Kim, Ho-Dong

This article reached the following conclusions.

(1) The dynastic name ‘Da Yuan’ was a Chinese appellation of the Mongolian term ‘Yeke Mongghol Ulus’. It was officially adopted by Qubilai and replaced other Chinese appellations like ‘Da Menggu Guo’ or ‘Da Zaho’. It was only used in the region where Chinese scripts were used such as Korea and Vietnam. Therefore, ‘Da Yuan’ should not be understood as, or equated with, one of the successor states which we have called Yuan Dynasty, ruling East Asia including China, of the Yeke Mongghol Ulus.

(2) However, Chinese literati in the 13th and the 14th centuries who had maintained the historical sense of dynastic continuity regarded ‘Da Yuan’ as a Chinese dynasty succeeding Han, Tang and Song. Contemporary scholars also accept this viewpoint uncritically, so ‘Da Yuan’ and Yuan Dynasty came to be regarded as synonyms, in the meantime, non-Chinese during the time of the Mongol empire did not know ‘one’ China, but for them there were two different regions called ‘Calay’ and ‘Manzi’.

The Mongols and the West Asians had another name for the realm of Qa’an, which we have called Yuan Dynasty: ‘Ulus of Qa’an’. This appellation is congruent with other designations such as ‘Ulus of Chaghatay’, ‘Ulus of Jochi’, etc. These terminologies show the fact that ‘Da Yuan =

⁸⁶ 岡田英弘 譯註, 『家古源流』(東京, 2004), p.224.

⁸⁷ Тухайлбал Т. А. Алсен-ы судлагаа, жишээ нь, *Commodity and Exchange in the Mongol Empire* (Cambridge: Cambridge University Press, 1997) болон *Culture and Conquest in Mongol Eurasia* зэргийг дурдаж болно.

Yeke Mongghol Ulus' was a conglomeration of multiple uluses.

4. From the top of the conglomeration ruled the Qa'an whose supreme authority was acknowledged by the leaders of other uluses. Only he could employ the terms like 'qa'an' (= great khan) and 'jarligh' (=edict). He also intervened in the succession matters within uluses. 'Ibis phenomenon is one of the evidences showing the unity of the Mongol empire as a political structure. Under this sense of unity was lying the solidarity among the so-called 'Golden Clan' (Allan Urugh), i.e. the descendants of Chinggis Khan, based on their consanguineous tie. This was why Qa'an was called 'aqa' meaning 'elder brother' and 'senior'. He had two faces of 'sovereign' and 'elder brother' of the ruling group. However, as time passed, this sense of unity became slackened and his authority as 'aqa' was also weakened.